

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН



ШИНЭ НОМЫН

2017.04.14

№ 01

ЭМХЭТГЭСЭН:

Номзүйч М. Кунай

Номзүйч М. Намжилмаа

Электрон каталог:
<http://catalog.num.edu.mn>

ГАРЧИГ

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ	3-4
МАТЕМАТИК, ФИЗИК	4-5
ГЕОФИЗИК, ГЕОЛОГИ	5-6
ГАЗАР ЗҮЙ	6
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН	6-7
МАЛ АЖ АХУЙ, ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ	7
СТАТИСТИК, ТОО БҮРТГЭЛ	7-8
МОНГОЛЫН ТҮҮХ СУДЛАЛ	8
УГСААТАН СУДЛАЛ	8-9
БАНК, САНХҮҮ	9-10
МАРКЕТИНГ, МЕНЕЖМЕНТ	10-11
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН	11-12
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	12-13
СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ	13-16
БОЛОВСРОЛ СУДЛАЛ, ТЕЛЕВИЗ БА НИЙГЭМ	16-17
НОМЫН САН БА МУЗЕЙ СУДЛАЛ	17-18
ХЭЛ ШИНЖЛЭЛ	18
АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ	18-19
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ	19-20
МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ	20-22
ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ	22-27
УРАН БАРИЛГА	27
ШАШИН СУДЛАЛ	27-28
ГҮН УХААН, ЁС СУРТАХУУН	28-29
НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ, НЭВТЭРХИЙ ТОЛЬ БИЧИГ	29-30
ОРОС, АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ НОМНУУД	30-32

Товчилсон үгийн тайлбар:

БУН унш-Байгалийн ухааны номын уншлагын танхим /Хич-2, №307/
НУН унш-Нийгмийн ухааны номын уншлагын танхим /Хич-2, №213/
ГНОФ-Гэрээр ном олгох фонд /Хич-2, №135/
ГФ-Гадаад фонд /Хич-2, №136/
Лав.-Лавлагааны фонд /Хич-2, №108/
БС- ийн номын сан /Хич-5, №505/
ОУХНУС-ийн номын сан /Хич-5, №304/
ХЗС-ийн номын сан /Хич-3, №205/
ХШУИС-ийн номын сан /Хич-3, №113/
ШУС-БУС-ийн номын сан /Хич-7, №115/
ШУС-БУС-ийн номын сан /Хич-1, №110/
ШУС-БУС-ийн номын сан /Хич-3, №221/
ШУС-НУС-ийн номын сан /Хич-2, №219/
ШУС-ХУС-ийн номын сан /Хич-2, №334/

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

Монгол улс дахь боловсролын ногоон барилгын загвар болон үнэлгээ.- УБ., 2016.- 90х.

Энэхүү тайлан нь ногоон технологи, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг судалдаг БНСУ-ын Засгийн газрын харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн болох Ногоон Технологийн Төв болон ногоон хөгжлийг хөгжүүлэн дэмжих зорилго бүхий Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагын Монгол улсад боловсролын ногоон барилгын төслийг зохицуулах, техник, эдийн засгийн судалгааг явуулах хамтын ажиллагааны үр дүн бөгөөд энэ тайланд Монгол улсын одоогийн орчин, нөхцөл байдал, боловсролын бодлого зэргийг судалж, ногоон технологийн сонголт, ногоон барилгын загвар зураг, гүйцэтгэлийн болон эрчим хүчний үнэлгээ, мөн эдийн засгийн үнэлгээ зэргийг багтаажээ.

20.18+38.1

М-69

/БУН унш-3ш/

Т-18542-18544



Монгол улсад ногоон эрчим хүчний систем хөгжүүлэх стратеги 2013-2035: Өргөтгөсөн хураангуй тайлан / Орч. Т.Хишигт; Хян. Ц.Булганмөрөн.- УБ., 2015.- 84х.- ISBN 979-11-952673-0-9.

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага нь Монгол улсын засгийн газартай хамтран Монгол улсад ногоон эрчим хүчний системийн олон төрлийн дүр зураглал, боломжит эх үүсвэрүүдийг судлан ажиллаж байгаа билээ. Энэ ажлын хүрээнд боловсруулсан Монгол улсын эрчим хүчний салбарыг хөгжүүлэх боломжит хувилбар, мөн цахилгаан дулаан хангамж, барилга, тээвэр, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбаруудыг хөгжүүлэх төлөвлөгөөний хувилбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үр дүн, зөвлөмж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх тайланг толилуулж байна.

20.18+31

М-69

/БУН унш-2ш/

Т-18545-18546

Нийгэм, эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэх нь: Олон улсын 3-р бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл: Монгол, орос, англи хэл дээр: 2 боть / Ерөн. ред. Г.Нямдаваа; Ред. Д.Амарсайхан, Б.Батбуян, С.Гомбобаатар ба бус.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- ISBN 978-99978-4-283-1.

Байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн асуудлыг сонирхон судалдаг шинжлэх ухаан, боловсролын болон төрийн байгууллагын ажилтнууд, нийт уншигчдад зориулагдсан энэхүү номны 1-р ботид газрын доорхи болон гадаргын ус судлал, усны экогеохими, экосистем, ой судлал, ойн төлөв, ашиглалт ба хамгаалалт, ойн түймэр, шавьжид нэрвэгдсэн ойг нөхөн сэргээх, ондатр, монгол бөхөн, загас, идлэг шонхорын судалгаа, хамгаалал, ургамал судлал; 2-р ботид газрын төлөв байдал, хөрс судлал, газар ашиглалт, бэлчээрийн төлөв байдал, монгол орны цөлжилт, газрын доройтол, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, аялал жуулчлал, тусгай хамгаалалттай газар нутаг, хүлэмжийн хий, байгаль орчны аудитын хөгжил, агаарын бохирдолын талаарх илтгэлүүд оржээ.

20.18

Б. 1. -333х. Т-18533-18534



Н-58

Б. 2. -385х. Т-18535-18536



Ногоон хөгжлийн бодлого: Гарын авлага.- УБ., 2015.- 80х.- (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам)

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн энэ номонд Монгол улсын ногоон хөгжлийн бодлого, энэ бодлогын талаарх товч танилцуулга, Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн практикийн талаарх олон улсын туршлагаас мөн Монгол улсын ногоон хөгжилтэй холбоотой зарим төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн тоймын талаар өгүүлжээ.

20.18я7

Н-67

/БУН унш-5ш/

Т-18539-18541

Ногоон хөгжлийн товхимол / Боловс. П.Түвшинжаргал, Л.Болор, А.Халиунаа; Хян. Ц.Уранчимэг, Э.Баярмаа.- УБ., 2016.- 121х.- (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам)



Энэ номонд даян дэлхийн хөгжлийн төлөвлөгөө, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 тойм, ногоон хөгжлийн бодлого түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хууль эрх зүй, ногоон хөгжлийн төлөөх санаачлага, Парисын хэлэлцээр-Монгол улс, тогтвортой хөгжлийн боловсрол, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагын Монгол дахь үйл ажиллагаа, ногоон хотын хөгжил, төр хувийн хэвшлийн түншлэл мөн ногоон хөгжлийн үзүүлэлтийн талаар өгүүлжээ. Түүнчлэн ногоон амьдралын хэв маягын үзүүлэлтийг хавсралтанд оруулжээ.

20.18+65.5

Н-67

/БУН унш-3ш/

Б-24583-24585

Ногоон хөгжлийн шилдэг туршлага: Улс орнуудын туршлагын сургамжууд / Хян. Ц.Булганмөрөн.- УБ., 2014.- 311х.



Дэлхийн олон улс оронд ногоон хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн туршлагыг баримтжуулж, энэхүү үнэлгээний тайланг боловсруулсан ба үнэлгээний тайланг боловсруулахад 75 зохиогч оролцож, дэлхий дээрх 60 гаруй хөтөлбөрийг судлан үзжээ. Ногоон хөгжлийн дүн шинжилгээ хийх, төлөвлөх, зорилтоо тодорхойлох, үр ашгийг үнэлж мэдээлэх, хувилбарууд, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт босгох, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хяналт тавихад улс орнуудад нийтлэг мөрддөг хоорондоо уялдаа холбоотой 9 үе шатны тухай энэ номонд өгүүлэх бөгөөд ногоон хөгжлийн бодлого боловсруулах, туршлага хэрэгжүүлэхэд гар бие оролцож буй шинжээч, зөвлөх болон бодлого боловсруулагч нарт гарын авлага болох ажээ.

20.18+65.5

Н-67

Т-18529

МАТЕМАТИК, ФИЗИК

Монгол улсын гавьяат багш Б.Банзрагчийн нэрэмжит математик, байгалийн ухааны олимпиад: Архангай, 2007 / Эрхл. Р.Ринчинбазар; Хян. Л.Хадхүү.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 82х.- ISBN 978-99973-3-753-5. Оюуны чадвар сайтай, математикт авьяастай сурагчдыг бага наснаас нь



илрүүлж дэмжин хөгжүүлэх, багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор Монгол улсын гавьяат багш Б.Банзрагчийн нэрэмжит математик-байгалийн ухааны олимпиадыг зохион явуулсан ба энэ товхимолд уг олимпиадын бодлого даалгаварууд, хариу тайлал, мөн Банзрагч багшийн намтар, шавь нарын бичсэн дурсамжууд оржээ.

22(1)г

М-69

Б-24586-24587



Содбилэг Ч. **Ертөнцийн товч түүх** / Ред. Х.Чагдаа.- УБ.: Зоригоо дизайн ХХК., 2016.- 369х.- ISBN 978-99973-938-6-9.

Орчлон ертөнц, байгаль дээр явагддаг үзэгдэл, юмсын шалтгаан, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, зүй тогтол, орчлон ертөнц хэрхэн, яаж үүссэн, од гариг, материйн хөдөлгөөн янз бүрийн үзэгдэлд хүргэдэг тухай, орон зай, цаг хугацаа гэж юу вэ, сансар огторгуй яагаад заавал одоогийн байгаа шигээ байгаа вэ, яагаад өөр хэлбэрээр байж болоогүй вэ, ямар ерөнхий зүй тогтол байна вэ, эсвэл өөр өөрийн гэсэн тусдаа хуультай юу, өнгөрсөн хугацаанд ямар байсан, ирээдүйд өөрчлөгдөх үү гэсэн физикийн шинжлэх ухааны асуултуудад энэ ном хариулт өгөх болно.

22.3

С-52

/БУН унш-3ш/

Б-24588-24590

ГЕОЛОГИ, ГЕОФИЗИК

Даваажав Я., Пүрэвсүрэн Б. **Монгол орны зарим ордын нүүрсний петрографийн судалгаа** / Ред. Б.Авид, Н.Баттулга; Эх бэлт. Ж.Намхайноров, М.Батцэцэг.- УБ.: Тоонотпринт, 2016.- 216х.- (ШУА. Хими, Химийн Технологийн Хүрээлэн, Нүүрсний Хими Технологийн Лаборатори)

ISBN 978-99973-958-5-6. Монгол орны янз бүрийн бүс нутагт байрладаг, улс орны түлш эрчим хүчний хөгжилд чухал ач холбогдолтой, улсын эдийн засгийн ирээдүйн хөгжилд чухал нөлөө үзүүлэх, янз бүрийн шинж чанар бүхий нийт 8 ордын нүүрсний техникийн үндсэн үзүүлэлтүүд, элементийн бүрэлдэхүүн, витринитийн ойлтын зэрэг R_0 , болон мацерал бүлгүүдийг анх удаа тодорхойлсон ба стандартын дагуу бэлтгэсэн сорьцуудад олон удаагийн микроскопын ажиглалтуудыг хийж олон талаас нь иж бүрэн авч үзэн нүүрсний бичил бүтэц байгууламжийг дэлгэрэнгүй тайлбарласан нь энэхүү бүтээлийн үнэ цэнэ оршино.

26.31

Д-12

/ХШУИС-2ш/

Т-18584-18585



Кийз С. **Геофизикийн цооногийн аргын үндэс**: Газар доорхи усны хайгуулд хэрэглэдэг цооногийн аргачлалууд / Орч. Н.Жаргал; Эх бэлт. А.Чинбат.- УБ.: ВСІ., 441х.- (АНУ-ын Геологийн Судалгааны Хүрээлэн) АНУ-ын Геологийн Судалгааны Хүрээлэнгээс усны эх үүсвэртэй холбоотой тусгайлсан ажлыг төлөвлөх болоод хийж гүйцэтгэх арга ажиллагааг тодорхойлсон цуврал зааврыг хэвлэн гаргасан болно. Газар доорхи усны хайгуул, судалгааны ажил хэрэглээг гол төлөв жишээлж дэлгэрэнгүй агуулгатайгаар тайлбарласан, лавлах сурвалж болохуйц, бүрэн хэмжээний бүтээл болох бөгөөд геофизикийн цооногийн аргыг хэрэглэдэг салбарынхан болоод энэ шинжлэх ухааныг шинээр судалж байгаа оюутнууд, энэхүү салбарт ажилладаг геологичид, гидрогеологичид зэрэг хүмүүст анхан шатны цогц ойлголт өгөх ажээ.

26.2

К-38

/БУН-унш-7, ШУС-БУС-10ш/

Б-24605-24607

Минжин Ч. **Монголын литостратиграфийн кодекс** / Ред. С.Хишигсүрэн.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх үйлдвэр, 2016.- 51х.: Геохронологийн таблицтай.



Энэхүү кодекс нь литостратиграфийн үндсэн ойлголт, нэр томьёо, нэгж ялгах журам, нэгжийг хүчин төгөлдөр болгох арга, номенклатурын дүрэм, зохиогчийн эрх, нэгж, ангиллыг хэвлүүлэх заавар зэргийг тайлбарлан тусгасан цогц баримт ажээ. Үүний зориулалт нь манай оронд литостратиграфийн үндсэн ойлголт ба нэр томьёог нэг утгаар ойлгож, геологийн судалгаанд тогтвортой удаан хэрэглэх, мөн литостратиграфийн нэгжийг бодит үндэслэлтэй ялгаж, номенклатурын дүрмийн дагуу нэр өгч, цаашдын судалгаанд ашиглахад оршино. Мөн энэ номонд 2015 он 1 сард гарсан олон улсын Хроностратиграфийн таблиц, Монголд хэвшсэн ойлголтуудыг баримтлан “Геохронологийн таблиц”-ийг шинэчлэн хавсаргажээ.


26.3

М-55

/ШУС-БУС-

5ш/

ГАЗАРЗҮЙ



Газарзүйн салбар 60 жилд: МУИС-ийн Газарзүйн салбар байгуулагдсаны 60 жилийн ойд зориулав / Хян. М.Баянтөр, В.Батцэнгэл; Эмхт. Ц.Базарханд, Д.Даваадорж.- УБ., 2016.- 184х.

МУИС-ийн Газарзүйн салбар анх 1956 онд байгуулагдсанаас хойшхи түүхэн 60 жилийн тухай өгүүлэх энэ номонд газарзүйн мэдээллийн системийн хөгжил, нийслэлийн бүс нутгийн орон зайн төлөвлөлт болон газар ашиглалт, газарзүйн хичээлд сорил туршилтын арга зүйг нэвтрүүлэх, говийн бүсийн хөрс, аялал жуулчлал дахь чанарын судалгаа,

Хорго вулканы үүслийн тухай эрдэм шинжилгээний илтгэлүүд, Газарзүйн тэнхимийн профессор багш нарын бүрэлдэхүүн, сургалт, тус салбарт ажиллаж байсан багш нар, гадаад харилцаа, зочин профессорууд, мэргэжилтэн бэлтгэж ирсэн түүхэн замнал, өнөөгийн бүтэц бүрэлдэхүүний талаар өгүүлжээ.


26.8

Г-16

/БУН унш-3, ШУС-БУС-3ш/

Т-18568-18570

ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН



Инженерийн лавлах: Геологи, Ашигт малтмал, Ашигт малтмалын эрэл хайгуул, Геофизик / О.Гэрэл, Ж.Лхамсүрэн, Г.Ухнаа ба бус.; Ерөн. ред. О.Гэрэл; Ред. Б.Алтанзул, Б.Мөнхцэнгэл, Б.Батхишиг.- УБ.: ШУТИС., 2016.- 750х.- ISBN 978-99978-0-020-6.

Геологи уул уурхайн сургуулиас гаргаж байгаа инженерийн лавлах цувралын 13 дугаар нь “Геологи” нэрийн доор хэвлүүлсэн геологийн салбарын багш нарын хамтын бүтээл юм. Геологийн зураглал, ашигт малтмалын эрэл хайгуул болон уул уурхайн ашиглалтын ажил явагдаж байгаа энэ үед геологийн процессууд, түүний үр дүнд үүсдэг эрдэс, чулуулаг, хүдрийн гарал үүсэл, түүнийг хайж илрүүлэх аргачлалын талаар зөвхөн геологийн мэргэжилтэн, оюутнаас гадна ордын ашиглалт хүдрийн баяжуулалт явуулдаг мэргэжилтэн болон геологийн

шинжлэх ухааныг сонирхсон, энэ талаар мэдлэгтэй болохыг хүссэн хүмүүст зориулсан мэдээллийн эмхэтгэл болно.

30у.я2+26.34

И-62

/БУН-унш-7, ШУС-БУС-10ш /

T-18581-18583

МАЛ АЖ АХУЙ

Мягмаржав Б. **Өвөр Азийн бэлчээрийн мал аж ахуй-Дэлхийн зах зээлд IX** / Ред. С.Лувсандорж.- УБ.: Ном хур, 2016.- 248х.- (НУДС. Монголын Түүх Соёл, Нийгэм Судлалын Академи).- ISBN 978-99962-62-36-4.-


Энэ бүтээлд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг 40 орчим орны байгаль, цаг уур, мал аж ахуй болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт, бүтэц, төрөлжилт, байршил болон салбаруудын уялдаа, өнөөгийн байдлыг үнэлж, хэтийн төлөвийг 2020 он хүртэл тодорхойлжээ.

5+65.325.2


М-98

/ШУС-БУС-3ш/

T-18574-18575



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ



Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм цацрагийн аюулгүйн норм: Цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм стандартын цуврал №1 / Хян. Г.Манлайжав; Эмхт. Э.Нямдаваа.- УБ.: 2016.- 238х.- (Цөмийн энергийн комисс)


Цөмийн технологи, цацраг идэвхт материал, ионжуулагч цацрагийн үүсгүүр, тэдгээрийн хэрэглээний ач тус нь учруулж болзошгүй эрсдэлээс үлэмж их буюу цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг зохих түвшинд хангаж, тунгийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байх тохиолдолд ашиглах үндсэн зарчимтай. Хурдацтай явагдаж буй нийгэм эдийн засаг, шинжлэх ухаан, цөмийн технологийн хөгжилтэй уялдуулан олон улсын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, стандартуудыг үндэслэн Монгол Улсын Цөмийн энергийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид нийцүүлж “Цацрагийн аюулгүйн норм”, “Цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”-ийг Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас зохион байгуулж боловсруулсан.

51.24+30н

Ц-26

T-18537-15538

СТАТИСТИК, ТОО БҮРТГЭЛ



Чимгээ Д. ба бус. **SPSS шинжилгээ үр дүн тайлбар** / А.Болор, А.Энэрэл; Ред. Д.Хонгорзул, А.Болор.- УБ., 2015.- 291х.- ISBN 978-99973-906-0-8.

Уншигч та бүхэнд нийгмийн статистикийн шинжилгээнд SPSS програмыг хэрхэн ашиглах талаар бичсэн уг номонд өгөгдөл цуглуулах, өгөгдлийн бүтэц, нийгмийн статистикийн үндсэн ойлголтууд, нийгмийн статистикийн шинжилгээ хийх аргууд, шинжилгээний үр дүнг тайлбарлах арга зүйг тусгасан байна. Ялангуяа өргөн хэрэглэгддэг регрессийн шинжилгээний талаарх ойлголт, түүний үр дүн ба тайлбарыг нэлээд дэлгэрэнгүй авч үзжээ.

60.6+32.973-018

Ч-62

/НУН-унш-4, ГНОФ-3, БС-5ш/

Б-24597-24599

МОНГОЛЫН ТҮҮХ



Чулуунжав Д. **ХІХ-ХХ зууны монголын дээд эрдэмт гэвш нар** / Эрхл. Р.Ринчинбазар; Ред. Г.Чулуунбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 125х.- (“Увдисын шүтээн” ХК).- ISBN 978-99973-3-520-3.

Энэхүү номонд Монголын уудам нутгийн нэгээхэн хэсэг болох Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу буюу одоогийн Архангай аймгийн Цахир суманд төрсөн эрдэмт мэргэн гэвш нар – Гэсэр багштан хэмээн алдаршсан Тойн эрдэнэ Цэвээнраашийн Чүлтэмжамц, аугаа эмч, аграмба цорж Равсалын Санжаажав, Дорно дахины уламжлалт анагаах ухааны нэрт төлөөлөгч Лүнриг Дандар, Цастын орноо бурханчлан шүтэгдсэн гэвш Дарамбазарын Сэнгээ ринбүчи нарын тухай өгүүлсэн болно.

63.3(1)

Ч-89

T-18528

Шуушингаа Ч. **Хорьдугаар зуун дахь үзэмчиний нүүдэл суудал** / Хян. А.Пунсаг.- УБ.: Мөнхдардас, 2014.- 314х.- ISBN 978999739332-6.


Үзэмчин аймаг бол эртний монголын язгуур ястны нэг бөгөөд XIII зууны эхэн үеэр ойн иргэдийн аль нэгэнд багтан явж байгаад, XIII зууны дунд үеэр Толуйн отгон хөвгүүн Аригбухагийн өмч иргэн болж, Алтай уулын ар өврөөр нүүдэллэн амьдарч байсан хэмээн түүх сударт тэмдэглэсэн нь бий. Уг бүтээлд үе улирсан түүхийг XX зууны зүүн үзэмчин хошууны жишээн дээр хамгийн сүүлийн ноён хүртэл нь тодорхой гаргаж өгснөөс гадна үзэмчин монголчуудын ёс заншлыг маш дэлгэрэнгүй тоочин тэмдэглэжээ. Ер нь үзэмчин монголчуудын зан үйл нь монгол туургатны нийтлэг онцлог шинжийг бүрэн төгс хадгалснаас гадна маш өвөрмөц онцлог бүхий хувцас засал, ураг хуримын зан үйл, бөхийн өмсгөл зэрэг олон зүйлээрээ монгол туургатны өв соёлыг баяжуулж ирсэн гэдгийг уг бүтээлээс мэдэж болно.

63.3(1)

Ш-93

Б-24717

УГСААТАН СУДЛАЛ



Етекбай Т. **Олон улсын наурызын баяр**.- УБ.: Китаб, 2017.- 63х.- ISBN 978-9997-804-525.

Дэлхийн соёл иргэншлийн түүхэнд Наурыз хэмээх ойлголт нэн эртнээс байраа эзэлжээ. Энэ ойлголтын нэр, агуулга, мөн чанарыг судлаад үзэхэд дорно зүгийн ард түмний ахуй амьдрал, баяр баясгалан, итгэл үнэмшлийн тодорхой илэрхийлэл болж олон мянган жилийн тэртээгээс үүссэн өв соёлын тоонд багтдаг болох нь тодорхой байдаг. Зохиогч энэхүү товхимолд Наурызын баярын тухай казахын ард түмний дунд тархсан үлгэр домог, казах үндэстэн Наурызыг тэмдэглэж ирсэн уламжлал, ёс заншил, дэг жаяг, бэлэгдэл, казахын ард түмэн хэдийнээс тэмдэглэдэг болсон тухай дэлгэрэнгүй өгүүлжээ.

63.5

Е-80

/НУН унш-3ш/

Б-24715-24716

Нүүдэлчдийн өв судлал: Tomus XVII Fassuculus 1-27.- УБ.: Соёмбо, 2016.- 299х.- (Монголын үндэсний музей).- ISBN 978-99929-1-499-8.

Музей судлал сэтгүүлийг Улсын Музейн удирдах газраас эрхлэн 1968 оноос нийтэлж эхэлсэн бөгөөд 2001 оноос Монголын Үндэсний Түүхийн Музейгээс гаргаж байв. 2008 оноос Нүүдэлчдийн өв судлал нэрээр гарч буй эрдэм шинжилгээний цуврал бичгийн энэхүү дугаарт эртний судлал, түүх судлал, угсаатан судлал, соёл урлаг судлал, хэл шинжлэл, дурсамж, нийтлэл зэрэг агуулгын хүрээнд 20 гаруй судлаачдын судалгааны бүтээл, нийтлэлийг хамруулжээ.



63.5

H-88

T-18558-18559

БАНК, САНХҮҮ



Банк санхүүгийн нэр томъёоны товч тайлбар толь: Банк, санхүү, татвар, даатгал, хөрөнгө оруулга, хөрөнгийн үнэлгээ / А.Ганзориг, Л.Болд, М.Базаррагчаа ба бус; Хян. Д.Моломжамц, Г.Гантогтох, Р.Амаржаргал, Д.Батжаргал.- УБ.: Мөнхийн үсэг, 496х.- ISBN 999623-786-9.

Банк, санхүүгийн салбар эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед санхүүгийн үг хэллэг, ойлголтыг нэг мөр болгон тогтоох, хэрэглэх явдал нэн чухал болж байгаа бөгөөд нийгмийн хөгжлийн энэхүү шаардлагад нийцүүлэн, санхүүгийн шинжлэх ухааны ухагдахууныг монгол хэлээр амар хялбар ойлгож ухаарах, оновчтой зохистой хэрэглэх боломжийг олоход нэмэр болох зорилгоор энэхүү 6000 орчим толгой үг бүхий тайлбар толийг гаргажээ.

65.26я2

B-26

/НУН-унш-3, БС-5ш/

T-18586-18587

Норовдондог Ц. **Ипотекийн үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудал:** Бодлогын судалгаа, зах зээлийн загварууд, эрх зүйн шинжилгээ / Ред. Ч.Онончимэг.- УБ.: Адмон, 2011.- 105х.- ISBN 978-99962-0-367-1.

Ипотекийн үнэт цаасны зах зээл нь үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлээр дамжуулан урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж барилгын салбарт чиглүүлэх, иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцаар хангах сонгодог зах зээлийн тогтолцоо мөн боловч банк санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, бусад оролцогч субъектууд болон Засгийн газрын нэгдмэл үйл ажиллагааг хангасан цогц систем учраас зах зээлийн ажиллах механизм, зохицуулалтын хувьд нарийн төвөгтэй, эрсдэлтэй зах зээлд тооцогддог. Энэхүү эмхтгэл нь ипотекийн үнэт цаасны зах зээл, банк санхүү, хөрөнгө оруулалтын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд, оюутан судлаачид, хууль тогтоогчид бодлого боловсруулагчид болон иргэд, байгууллага, хувь хүмүүст шаардлагатай мэдээллийн томоохон эх сурвалж, гарын авлага болох юм.

65.262.2

H-74

/НУН-унш-3, БС-5ш/

T-18626-18627



Хувь хүний санхүү: Сурах бичиг / Н.Батжаргал, Д.Лхагвадорж, Л.Оюун ба бус.; Хян. Ц.Болормаа.- УБ., 2016.- 222х.- (Монгол Улсын Засгийн газар. Монгол Банк)

Энэ сурах бичгээр хувь хүн та өөрийн санхүүгээ зөв удирдан жолоодох, тухайлбал, хувь хүний санхүүгийн талаарх үндсэн ойлголт, тодорхойлолтууд, орлого, зарлагаа тооцоолох, хянах, хуримтлал,

хадгаламжтай болгох, хөрөнгө мөнгөө зарцуулахтай холбогдон гарч болох аливаа эрсдэлт байдлаас сэргийлэх, хамгаалах, эдийн засаг, санхүүтэй холбоотой зөв, оновчтой шийдвэр гаргах зэрэг өөрийн өдөр тутмын болоод ирээдүйн эдийн засгийн амьдралд нэн шаардлагатай, мэдвэл зохих хувь хүний санхүүгийн мэдлэг, ур чадварыг эзэмших юм.

65.261я73

Х-65

/НУН-унш-3,БС-10ш/

Т-18519-18520

Хувь хүний санхүү: Дасгал ажлын дэвтэр / Н.Батжаргал, Д.Лхагвадорж, Л.Оюун ба бус.; Хян. Ц.Болормаа.- УБ., 2016.- 111х.- (Монгол Улсын Засгийн газар. Монгол Банк)

“Хувь хүний санхүү” хичээлийн хүрээнд сорилго тест, хамгийн оновчтой, зөв хариултыг сонгох дасгал, кейс, бодлого, сэдвийг бататгах асуулт зэрэг олон хувилбар бүхий дасгал ажлын номыг боловсруулжээ. Энэхүү дасгал ажлын ном “Хувь хүний санхүү” хичээлийг сонирхон судалж буй оюутнууд хичээлээр олж авсан онолын мэдлэгээ бататгахад тус нэмэр болох юм.

65.261я7

Х-65

/НУН унш-3, БС-10ш/

Б-24580-24581



МАРКЕТИНГ, МЕНЕЖМЕНТ



Бурмаа Л. **Маркетингийн судалгаа** / Ред. Я.Отгонсүрэн.- УБ.: Алмазпресс, 2017.- 265х.- ISBN 978-99973-3-988-1.

Энэхүү сурах бичгийг гадаадын болон өөрийн орны нэр хүндтэй багш, судлаачдын сүүлийн үеийн бүтээлүүдийг ашиглан бичсэн. Уг сурах бичиг нь 17 бүлэгтэй бөгөөд маркетингийн судалгааны үйл явц, судалгааны арга зүй, статистикийн аргачлалуудыг тодорхой жишээнүүдээр тайлбарлаж үзүүлсэн болно. Шинэ зуунд зах зээлийн өрсөлдөөн улам ширүүсч технологи хурдацтай хөгжин, дижитал хэрэглээ өсөн нэмэгдэхийн хирээр хэрэглэгчдийн хандлага, зан төлөв, эрэлт хэрэгцээ амьдралын хэв маяг, өөрчлөгдөж байгаа өнөө үед хэрэглэгчээ байнга судалж байх хэрэгцээ шаардлага улам бүр өсч байна.Үүнтэй уялдуулан Маркетингийн судалгаа номоо та бүхэндээ хүргэж байна.

65.290-2

Б-75

/ НУН унш-3, БС-5ш /

Т-18576-18577

Райнерт Э. **Баян орнууд хэрхэн баялаг бүтээсэн бэ? Буурай орнууд яагаад ядуу хэвээр үлддэг вэ?** / Орч. Ц.Батбаяр; Орч. ред. Б.Сувддулам.- УБ.: Монсудар, 2016.- 175х.- ISBN 978-99973-1-362-1.

Норвегийн нэрт эдийн засагч Эрик Райнерт энэхүү номдоо баян орнууд анхнаасаа чөлөөт худалдааг эрхэмлэж баян болоогүй, харин төрийн оролцоо, протекционизм, татвар татаасын бодлогоор боловсруулах үйлдвэрээ дэмжин тэтгэж хамгаалах замаар баяжсан болохыг эдийн засгийн түүхийн 500 гаруй жилийн туршлагад үндэслэн нотолсон байна. Ядуу буюу буурай хөгжилтэй орнууд улс орноо түүхий эдэд шүтэн хөгжүүлэх бус, харин боловсруулах үйлдвэр, хот сууринаа өргөжүүлэн, технологийн дэвшил, хүний хүчин зүйлд түшиглэн хөгжүүлэх ёстойг чухалчилжээ.

65.5



УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН



Ардчилсан Монгол Улс: Шилдэг үзмэрийн дээжис / С.Амарсанаа, Г.Ариунтуяа, Ч.Буяндэлгэр ба бус.; Ред. Д.Сүхбаатар; Зөвлөх С.Отгонжаргал; Орч. Х.Болормаа.- УБ.: 2016.- 195х.- (Монголын Үндэсний Музейн эрдэм шинжилгээний төв).- ISBN 978-99973-79-82-5.

XX зууны Монголын түүх бүхэлдээ туурга тусгаар улсын бүрэн эрхт байдал, эрх чөлөө, тусгаар тогтнолын түүх байлаа. 1990 оны цагаан морин жилийн хувьсгал бол монголчуудын түүхэнд гарсан томоохон ололт амжилт билээ. Түүхийн бодит үнэнийг дурсах, ололт амжилтаа бататгах, монгол хүн бүрийн оролцоо сэтгэлийн дэм, эв нэгдлийн дээд илэрхийлэл болсон түүхэн цаг үеийг мөнхжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргээ биелүүлж, Монголын үндэсний музей тухайн үед холбогдох үзмэр, эд өлгөөс 100 гаруйг дээжлэн авч, дагалдах эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, товч хураангуй тайлбар, өнгөт болон хар гэрэл зураг бүхий “Ардчилсан Монгол Улс” хэмээх эл бүтээлийг олон түмэндээ толилуулж байна.

66.63(1)
А-72

Т-18531-18532

Ли Куан Ю. Сингапурын хөгжлийн нууц: Гуравдагч ертөнцийн орон үсрэнгүй хөгжилд хүрсэн түүх: 1965-2000 / Орч. Н.Монголмаа; Ред. Б.Төмөр.- УБ.: Монсудар, 2015.- 773х.- ISBN 978-99973-1-389-8.


Жижиг арал дээр орших Сингапур нь Дэлхийн II дайнаас өмнө Англи улсын колони байсан төдийгүй уг аралд байгалийн баялаг байтугай ундны ус ч байхгүй, мөн Сингапурын оршин суугчдын ихэнх нь хятад үндэстэн боловч малай, энэтхэг гэх мэт олон үндэстнээс бүрдэж байсан юм. Гэвч энэ хотын ирээдүй Ли Куан Ю хэмээх хүний ачаар хөгжлийн оргил өөд чиглэж чаджээ. “Сингапурын гайхамшиг”-ийн эцэг, тус орны анхны ерөнхий сайд асан Ли Куан Ю дурдатгал номондоо авлига болон хар тамхины мафитай хийсэн тэмцэл, ард иргэдээ нэгдэн нягтрахыг, улс орондоо эмх журам тогтоож, гар хумхилгүй ажиллаж, байгалийн баялаггүй Сингапур улсыг хэрхэн дэлхийн хамгийн баян орнуудын нэг болгосон тухайгаа тун дэлгэрэнгүй өгүүлжээ.

66.3(5Син)8

Л-54

/НУН унш-7, ШУС-НУС-5ш/

Т-18596-18598



Прайс Л. Моди үзэгдэл: Энэтхэгийг өөрчлөх Нарендра Модигийн кампанит ажиллагааг дотроос нь ажигууд / Орч. Г.Ганболд; Ред. Б.Төмөр.- УБ.: Монсудар, 2016.- 265х.- ISBN 978-99973-1-336-2.

Зохиолч Ланс Прайс ерөнхий сайд Н.Моди болон түүний зөвлөхүүдтэй тусгайлан ярилцаж, тийнхүү олж мэдсэнээ уншигчидтай илэн далангүй хуваалцахаар “Моди үзэгдэл” хэмээх энэхүү номыг бичжээ. Энэтхэгийн шинэ ерөнхий сайд Нарендра Модиг бүх нийтийн сонгуулийн кампанит ажиллагаагаа тун өвөрмөц явуулснаар улсынхаа түүхэнд шинэ дээд амжилт тогтоолоо. Түүний энэхүү амжилт нь Энэтхэгийн ардчиллын жишгээр төдийгүй, дэлхийн түүхэн дэх сонгуулийн хамгийн том ялалтуудтай харьцуулж болохоор гайхамшигт үзэгдэл байлаа. Сонгуулиар олж авсан бүрэн эрх нь Модийг олон улсын тавцанд хамгийн хүчирхэг хүмүүсийн нэг болгов...

66.3(5Энэт)8

П-68

/НУН унш-7, ШУС-НУС-3ш /

Б-24692-24694

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Монгол Улсын хааны зарлиг: Түшмэлийн хууль / Бэлт. С.Батчимэг; Тайлбар үйлдсэн О.Батсайхан.- УБ.: Соёмбо, 2016.- 248х.- (Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи).- ISBN 978-99973-58-87-0.



Богд хааны зарлигаар Монголын нийгмийн бүхий л харилцааг зохицуулсан жаран таван дэвтэр Монгол Улсын Хууль зүйлийн бичиг зохиосон бий. Түүний дотор Түшмэлийн хууль, түшмэлийн засаг хэмээсэн таван дэвтэр байх бөгөөд түүнд төрийн түшмэл гэж хэн болох, түүнийг хэрхэн бэлтгэх, сонгон шалгаруулах, байлгах гээд бүхий л зүйлсийг тодорхой тусгасан байна. Энэхүү үндэсний уламжлалаа, барууны шилдэг онол лугаа зөвөөр хослуулах нь төрийн албаны хууль болон бусад журам боловсронгуй болгоход дэм болох юм.

67.3

М-69

/НУН унш-5ш/

Т-18550-18552



Монголын шүүх: 3 Боть / Ред. Ц.Зориг, Ж.Наранпүрэв, Ч.Нямсүрэн; Эмхт. Ш.Даваадулам, Н.Мөнгөнцэцэг, А.Баярцэцэг, Э.Энхжаргал.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- (Монгол Улсын Дээд Шүүх).- ISBN 978-99929-3-516-3.

Монголын шүүх хэмээх энэхүү гурван боть номны эхний хэсэгт монголын шүүхийн тухай хууль тогтоомжийн эмхтгэлийг; дараагийн хэсэгт монголын шүүхийн түүхэн хөгжлийн тойм, өгүүлэл нийтлэлийг; сүүлийн хэсэгт Монгол Улсын шүүхүүдийн түүхэн замнал, танилцуулгыг оруулж өгсөн ба монголын шүүхийн түүхийн 105 жилд хамаарах эрх зүйн эх сурвалжийг агуулсан томоохон бүтээл болжээ.

67(1)

М-69

/ХЗС -2ш/

Б.1: Хууль тогтоомжийн эмхтгэл.- 584х.

Б.2: Түүхэн хөгжлийн тойм өгүүлэл нийтлэл.- 382х.

Б.3: Монгол Улсын шүүхүүдийн түүхэн замнал, танилцуулга.- 495х.

Монгол Улсын 2002 ба 2015 оны эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа / Зөвлөх С.Нарангэрэл; Хян. Ж.Эрдэнэбулган; Эрхл. Т.Золбоо; Судлаач Б.Амарбаясгалан, С.Амартүвшин.- УБ.: Адмон, 2016.- 267х.- (МУИС-ийн ХЗС).- ISBN 978-99973-79-11-5.



Харьцуулсан эрх зүй судлалын нэгэн бүрэлдэхүүн хэсэг нь үндэсний хууль тогтоомжийг харьцуулж судлах явдал юм. Энэхүү харьцуулсан бүтээл нь эрдэмтэн судлаач, практик ажилтанд төдийгүй оюутан, магистрант, докторант нарт чухал хэрэглэгдэхүүн болох бөгөөд, харьцуулсан судалгааны лавлагаанаас Монгол Улсын Эрүүгийн хуульд ямар шинэчлэл хийгдсэн, ямар ойлголт, нэр томъёо хасагдсан, өөрчлөгдсөн, нэгтгэгдсэн тухай мэдэх боломжтой.

67.408(1)

М-69

/ХЗС-5ш/



Руссо Ж. **Нийгмийн гэрээ** буюу улс төрийн эрхийн зарчмууд / Франц хэлнээс орч. Ц.Батбуян; Ред. Н.Жавхлан.- УБ.: Монсудар, 2016.- 212х.- ISBN 978-99973-1-402-4.

Энэ бүтээлээ Руссо өөрийн амьдарч буй цаг үеийн улс төрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх замаар эхлүүлжээ. Энэ нь Руссогийн хоёр энгийн дүгнэлт бөгөөд эхнийх нь хүмүүс байгалийн жам ёсонд захирагдаж биш нийгмийн зохион байгуулалтанд бүрэн орсон нийгмийн зохион байгуулалт хийх боломжын тухай энд өгүүлжээ. Нөгөөтэйгүүр өнөөгийн хүмүүсийн амьдарч буй нийгэм яавч сайн нийгэм байж чадахгүй байгаа нь олон учир шалтгаантай. Цөөнх олонхыг захирч байгаа нь шудрага бус, энэ нь дан хүчтэний зөв гэсэн үндэслэл болоод байгаа юм. Одоогийн нийгэмд хүмүүс байгалиас заяагдсан хараат бус эрх чөлөөгөө булаалгаад оронд нь юу ч олж авч чадаагүй байна. Тэд өөрсдийн захирагддаг хуулиа өөрсдөө бичилцээгүй, харин тусгай эрх мэдэл бүхий хэдхэн тооны хүмүүсээр шийдүүлж байна. Эдгээр хууль нь нийтийн эрх ашигт үйлчлэхийн оронд, дан хүчтэний буюу баянчуудын эрх ашгийг л хамгаалж байдаг тухай энэ номонд өгүүлжээ.

67.400.6

P-89

/ШУС- НУС-3, ГНОФ-7ш /

Б-24686-24688

СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Ази судлал: Олон улсын эрдэм шинжилгээний хурал: Дугаар 1 / Эрхл. В.Батмаа, Ц.Баттулга; Бэлт. Б.Аззаяа.- УБ.: Удам соёл, 2015.- 504х.- ISBN 978-99973-73-19-9.

Энэхүү Ази судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Хүмүүнлэгийн ухааны салбар, Ази судлалын тэнхим, ШУТИС-ийн Гадаад хэлний институт, Ази судлалын тэнхим, МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Дорно дахины хэлний тэнхим, МУИС-ийн дэргэдэх Күнзийн Институт хамтран зохион байгуулжээ. Хуралд тавигдсан Монгол судлал, Хятад судлал, Япон судлал, Солонгос судлал, Түрэг судлал зэрэг Ази судлалын 60 гаруй багш, судлаачдын эрдэм шинжилгээний илтгэлийг нэгтгэн энэхүү эмхэтгэлд толилуулжээ.

72

A-34

T-18622



Acta historica: МУБИС-ийн Түүхийн тэнхимийн Эрдем шинжилгээний бичиг: Боть XVII.- УБ., 2016.- 296х.- ISBN 978-99978-4-152-0.

МУБИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн гаргадаг “Acta historica” эрдэм шинжилгээний сэтгүүл нь Монголын түүхийн судалгааны мэргэжлийн сэтгүүл юм. “Acta historica” сэтгүүлийн агуулга нь Монголын түүх, Археологи, Антропологи, Угсаатан судлал, Сурвалж судлал, Намтар судлал зэрэг тогтмол хэсгээс гадна Бичээс судлал, Чингис судлал, дурсамж, тэмдэглэл, орчуулга, шүүмж зэрэг нэмэлт булантай.

72+63.4


A-19

/НУН унш-7ш /

T-18547-18549

Архангай нутгаас төрсөн эрдэмтэд / Эмхт. Р.Ринчинбазар, Ш.Чунаг.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон, 2013.- 360х.- ISBN 978-99973-0-081-2.

Архангай аймагт төрж өссөн болон энэ нутгийн үр сад-эрдэмтэн, докторуудын амьдрал, үйл ажиллагаа, бүтээл туурвилын талаар товч өгүүлсэн энэхүү номонд 1961 онд хамгаалсан анхны эрдэмтнээс эхлээд 2013 оны шинэхэн доктор хүртэл нэр бүхий 300 гаруй хүний товч намтар багтсан нь нутаг орны түүхэнд бага ч атугай нэмэр болох цаашилбал өнөөгийн өсвөр үе, ирээдүйн түүхийг бүтээгчид энэ номтой танилцаж, олон сайхан бүтээлч эрдэмтдээс үлгэр дуурайл авах боломжийг гаргаж өгчээ.



72(1-M1)

A-77

T-18530



Боловсрол судлал: Эрдэм шинжилгээний бичиг: №19 /454/- УБ.: МУИС., 2016.- 67х.- (МУИС-Багшийн хөгжлийн төв).- ISSN 1818-8478.

Мэргэжлийн Дидактикийн Сургалт, Судалгааны төвөөс эрхлэн гаргасан “Боловсрол судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ удаагийн дугаарт “Оюутны сурах чадвар ба сэтгэл ханамж”, “Насанд хүрэгчдэд боловсрол олгох багшийг бэлтгэх асуудалд”, “Семинарын явцад оюутнуудыг идэвхжүүлэх арга барил”, “Дээд боловсролын хөтөлбөрийн хүрээнд ногоон эдийн засгийн хөгжлийг оруулах боломж болон түүний зарим судалгааны үр дүнгээс”, “Оюуны зураглалын аргыг сургалтанд туршсан дүнгээс” зэрэг сэдвээр бичсэн судлаачдын судалгааны ажил нийтлэлүүд оржээ.

72


B-55

/НУН-унш-2, Лав-1ш/

T-18553-18554

Газарзүйн асуудлууд: 2016(1), №16: Эрдэм шинжилгээний бичиг / Ред. Д.Амартүвшин.- УБ., 2016.- 162х.- ISSN 2312-8534.

Энэ дугаарт аялал жуулчлалын хөтөлбөрөөр суралцагчид, газар дахин төлөвлөлт, туул голын урсац, Хустайн орчны бүсийн тариалангийн газар, газар нутгийн үүргийн бүсийн төлөвлөлт, хот суурин ба тусгай хамгаалалттай газрын үнэлгээ, “Цонжин болдог” орчмын жуулчны баазуудын байгаль орчинд нөлөөлөх байдал, хил дамнасан бүс нутгийн аялал жуулчлалтай холбогдолтой судалгааны өгүүллүүд оржээ.



72+26.89

Э-73

T-18565-18567



Монголын хүн амын сэтгүүл: МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг №26/462/ / Ред. А.Солонго, Ц.Болормаа, Б.Энхцэцэг ба бус.- УБ., 2016.- 85х.- (Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн ХАССТ).- ISSN 2226-1389.

Монголын хүн амын сэтгүүл нь Монголын хүн амын судалгааны талбарт тулгамдаж байгаа болон бусад нийтлэг асуудлаар эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээл, тэмдэглэл, судалгааны ажлуудыг хэвлэн нийтэлж олны хүртээл болгодог. Энэ удаагийн дугаарт “Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах малчдын стратеги”, “Боловсролын үйлчилгээний хүртээмжид шилжих хөдөлгөөний үзүүлж буй нөлөө”, “Хувь хүний орлогын албан татварын орон нутгийн санхүүгийн чадавхид үзүүлэх нөлөө” сэдэвт судалгааны ажил, “Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, түүнийг хангах арга зам” сэдэвт сургалтын нийтлэлийг оруулжээ.

72+60.7

M-69

/НУН-унш-6, Лав-1ш/

T-18623-18625

Монголчуудын бичиг үсэг соёлын баримтат өв болох нь: Эрдэм шинжилгээ-онол практикийн хурлын илтгэлийн эмхэтгэл / Эмхт. Д.Энхтунгалаг; Хян. Б.Тунгалаг.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 92х. (БСШУЯ: Монгол Улсын Үндэсний Номын Сан)

Монгол Улсын Үндэсний Номын Сангийн сан хөмрөгт 3 сая гаруй ном байдаг ба түүний дотор дорно дахины судлал, Монгол судлалд хамаарах ном, хэвлэлийн бүтээгдэхүүн 10-16 хувийг эзэлдэг. Зөвхөн Монгол судлалын сан хөмрөгт гэхэд л 56 мянга гаруй ном байдаг бөгөөд тэдгээрээс 9000 гаруй нь монгол гар бичмэл байдаг байна. Монгол гар бичмэлүүд нь үнэ цэнийн хувьд түүх, соёлын хөдлөх өвийн ангилалд багтах бичгийн дурсгалт зүйл юм. Энэхүү илтгэлд Монголчуудын бичиг үсэг соёлын баримтат өв болох, монгол гар бичмэлүүдийн үнэ цэнэ хэд хэдэн хүчин зүйлээр тодорхойлогддог болохыг өгүүлжээ.



72+63.2(1)

М-69

Б-24713-24714



Политологи: Эрдэм шинжилгээний бичиг: №14(464).- УБ.: МУИС пресс, 2017.- 203х.- ISSN 2227-6904.

МУИС-ийн ШУС-ийн НУС-аас эрхлэн гаргасан энэхүү эрдэм шинжилгээний дугаарт улс төрийн философи, төрийн албан дахь улс төрийн нөлөөлөл, монгол бичиг, Их монгол гүрний төрийн байгуулалт, гадаадын хөрөнгө оруулалтанд нөлөөлж буй улс төрийн институци, намын имиж, уламжлалт болон харизмат легитимчлэлээс хууль ёст легитимчлэл рүү, олон улс дахь авлигын төсөөлөл, орон нутгийн удирдлага, улс төрийн боловсролын хөгжил, Монголын залуучуудын улс төрийн оролцоотой холбоотой судалгааны өгүүллүүд оржээ.

72

Э-73

/НУН унш-6, Лав-1, ШУС-НУС-5ш/

Т-18632-18634

Социологи: Эрдэм шинжилгээний бичиг: №11/456/ / Эрхл. О.Мөнхбат.- УБ.: МУИС., 2016.- 336х.- (МУИС-ийн ШУС-Нийгмийн Ухааны Сургууль)


Социологи- Нийгмийн ажлын тэнхимийн 25 жилийн ойд зориулан гаргасан энэхүү эрдэм шинжилгээний сэтгүүлд 50 гаруй багш, судлаачдын эрдэм шинжилгээний өгүүллүүдийг оруулжээ. Эдгээр өгүүллүүд нь монголын нийгмийн олон талт харилцаа, эдийн засаг, улс төр, социаль, эрх зүйн болон нийгэм-соёлын, нийгмийн халамж, хамгааллын хүрээний бодлого, харилцааны өөрчлөлтүүд зэрэг агуулгыг хамарсан шилдэг бүтээлүүд юм.

72+60.5

С-61

/НУН-унш-6, ШУС-НУС-10, Лав-1ш /

Т-18516-18518



Хайгуулчин: Үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний сэтгүүл: №56. -УБ.: Адмон, 2016.- 186х.- (Монголын Үйлдвэрлэлийн Геологчдын Холбоо)

Монголын геологийн судалгааны ажлын ачааны хүндийг үүрч, зүтгэж буй геологчидийн үүсгэл санаачилгаар бий болсон “Монголын Үйлдвэрлэлийн Геологчдын Холбоо” нь байгуулагдсан цагаасаа эхлэн геологчдийн дуу хоолой болж байгаа билээ. Тус холбооноос эрхлэн гаргадаг “Хайгуулчин” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт геологи,

ашигт малтмал, төр засгийн мэдээ, аргачлал, технологи, туршлага, үр дүн, мэргэжилтний дуу хоолой, мэдээлэл сурталчилгаа агуулгын хүрээнд 20 гаруй судлаачдын судалгаа, нийтлэлийг толилуулсан байна.

72+26.3

X-16

/ШУС- БУС-2ш/

Эрдэм шинжилгээний бичиг: Гадаад хэл соёл судлал, эдийн засаг, боловсрол судлал, менежмент №4 /405/- УБ.: МУИС Пресс, 2013.- 115х.- (МУИС-ийн Орхон сургууль)

Монгол Улсын Их Сургуулийн харьяа Орхон салбар сургуулиас эрхлэн гаргасан энэхүү эрдэм шинжилгээний бичигт гадаад хэл соёл судлал, эдийн засаг, боловсрол судлал, менежментийн салбаруудад хамаарагдах 20 гаруй судлаачдын судалгаа шинжилгээний бүтээлүүдийг хамруулжээ.

72

Э-73

/Лав-1ш/

T-18562-18563



Эрдэм шинжилгээний бичиг: №7 /447/- УБ.: МУИС Пресс, 2016.- 214х.- (МУИС-ийн Орхон сургууль)

Монгол Улсын Их Сургуулийн харьяа Орхон салбар сургуулиас эрхлэн гаргасан энэхүү эрдэм шинжилгээний бичигт бизнесийн удирдлага, боловсрол судлал, хэл шинжлэл, гүн ухаан, биеийн тамир, эрүүл ахуйн сэдвийн хүрээнд 30 гаруй судлаачдын судалгаа шинжилгээний бүтээлүүдийг хамруулжээ.

72

Э-73

/Лав-1ш/

T-18564

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Монгол Улсын Их Сургуулийн Завхан сургуулийн түүхэн хөгжил: Баримт, статистик, дурсамж, мэдээ 1974-2014 / Эмхт. Л.Баярмагнай; Зөвлөх Ц.Сайнжаргал, М.Эрдэнэчимэг.- Улиастай хот: Интерпресс, 2014.- 324х.

МУИС-ийн Завхан сургууль эрдмийн их өргөөнийхөө түүхт 40 жилийн ойд зориулан гаргасан энэхүү номондоо сургуулийн түүхтэй холбоотой баримт материал, онцлох үйл явдал, зарим ахмад багш, удирдлагуудын дурсамж дурдатгал, төгсөгчдийн амжилт бахархал, сургуулийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийг харуулсан ба ховор нандин гэрэл зургуудаас дээжлэн толилуулжээ.

74.58(1-М 9)

M-69

T-18621



ТЕЛЕВИЗ БА НИЙГЭМ

Жаргал С. Телевизийн соёлын асуудлууд / Ред. Ж.Долгорсүрэн.- УБ.: Ган шастир, 2016.- 248х.- ISBN 978-99973-51-52-4.

Соёлын олон талт оршихуйн нэг бол телевизийн соёл юм. Телевизийн соёл гэдэгт нэгдүгээрт, телевизийн уран бүтээл хийх үйл ажиллагаагаар тогтоогдсон хэм хэмжээ,



түүний үр дүнд бүтээгдсэн үнэт зүйлс, хоёрдугаарт телевизээр соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хадгалах хамгаалах үйл ажиллагааны хүрээ бүхэлдээ, гуравдугаарт телевиз- үзэгчийн харилцаа тус тус хамаарна. Өөрөөр хэлбэл телевизийн соёл хэмээх нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд телевизийн оршин ахуйн үндсийн үндэс билээ. Зохиогч 10 гаруй жилийнхээ судалгааны үр дүнг нэгтгэн энэхүү бүтээлдээ оруулжээ.

76.032

Ж-31

/НУН унш-7, ШУС-ХУС-5ш/

T-18578-18580

НОМЫН САН СУДЛАЛ

Номын санч-мэдээллийн ажилтны ширээнд: Гарын авлага / Эрхл. Д.Энхтунгалаг, Б.Цогжаргал, Г.Гүнжинлхам ба бус.; Ред. Д.Энхтунгалаг.- УБ.: Соёмбо, 2015.- 112х.- (Монгол Улсын Үндэсний Номын Сан).- ISBN 978-99962-2-454-6.

Номын санч- мэдээллийн ажилтны нэгэн үүрэг нь шинэ мэдээ мэдээллийг хэн бүхнээс урьтан олж, уншигч, хэрэглэгчдэд хүргэх явдал билээ. Үүний тулд номын сангийн фонд, каталог, лавлагаа номзүйн ажлыг зохих дүрэм журам, онолын үндсэн дээр зохион байгуулж, уншлага үйлчилгээний ажлыг явуулахад мэргэжилтэн бүрийн заавал мэдэж байх ёстой гол сэдвүүдийг энэ номонд оруулжээ.

78.3

Н-72

/ НУН унш-3, БУН унш-3, Лав-1ш /

Б-24594-24596



МУЗЕЙ СУДЛАЛ



Байгалийн өв судлал: Монгол Улсад орчин цагийн музей үүсч хөгжсөний 90 жилийн ойд зориулав. / Ред. зөвлөх Н.Зоригтбаатар, Б.Бадамцэцэг, Г.Цэцэцбадам ба бус.; Эмхт. хян. Т.Тодгэрэл.- Анхны дугаар.- УБ., 2014.- 151х.- (Байгалийн түүхийн музей).- ISBN 978-99973-825-3-5.

Байгалийн өв судлал хэмээх энэхүү эрдэм шинжилгээний цуврал бүтээлд Байгалийн түүхийн музейн үүсч хөгжсөн түүх, музейн сан хөмрөг дэх биологийн цуглуулгуудын зүйлийн бүрдэл, тоо хэмжээ, үзмэрийн төрөл, түүхэн цаг хугацаанд сан хөмрөгийг бүрдүүлсэн эрдэмтэн, судлаачид, цаашид баримтлах бодлого гэх мэт сан хөмрөгийн бүртгэлд боловсруулалт хийсэн судалгааны ажлыг танилцуулжээ.

79.1+20

Б-17

/БУН-унш-7ш/

Б-24707-24709

Байгалийн өв судлал: Дугаар 2 / Ред. зөвлөх Н.Зоригтбаатар, Б.Бадамцэцэг, Т.Тодгэрэл ба бус.; Эрхл. Б.Бадамцэцэг.- УБ., 2016.- 201х.- (Байгалийн түүхийн музей).- ISBN 978-99973-825-3-5.

Эрдэм шинжилгээний бүтээлийн энэ дугаарт Улсын төв музейн тайлбарлагч, эрдэм шинжилгээний ажилтан, хөхтөн амьтан судлаач, Байгаль орчны тэргүүний ажилтан, Алтан гадас одонт С.Цагааны музейн салбарт оруулсан хувь нэмрийг цуглуулгын дээж болсон үзмэрүүдээр чухалчлан толилуулж байна.

79.1+20



Б-17

/БУН-унш- 7ш/

Б-24710-24712

ХЭЛ ШИНЖЛЭЛ



Баяртогтох Н. Оюун билгийн сан хөмрөг: Монгол хэлний өвөрмөц хэлцийн зүйлчилсэн тайлбар толь / Хян. Б.Батрэгзэдмаа, Э.Удвал, Ө.Батбаясгалан.- УБ.: Адмон, 2017.- 704х.- ISBN 978-99978-4-265-7.

Зохиогч монгол хэлц үгийн зүйлчилсэн толь бичигтээ монгол өвөрмөц хэлц үгийн далд, гүнзгий утгыг тайлбарласан ба монголчууд маань хэлц үгэндээ ахуй амьдралынхаа онцлог, хэл сэтгэлгээнийхээ өвөрмөц чанар, соёл боловсрол, ёс суртахууныхаа ер бусын гайхамшгийг агуулан тээн ирснийг харуулж, Монгол хүмүүнээ төлөвшүүлж, монголоороо сэтгэн аж төрөхөд чиглүүлэх аргыг тусгасан нь бүтээлийн ач холбогдол орших юм. Эх хэлний сан хөмрөгөө мэдэх, үеэс үед өвлүүлэн хэрэглэх нь бидний эрхэм зорилго, улс эх орны минь тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын дархлаа болох билээ.

81.2М-4

Б-38

/ НУН унш-5, ШУС-ХУС-1, Лав-1ш /

Б-24600-24602

Гадаад хэл сургалтын онол, аргазүйн үндэс: Их дээд сургуулийн гадаад хэлний салбарын оюутнуудад зориулсан сурах бичиг / Ш.Туяа, Ц.Оюунсүрэн, Ч.Сэлэнгэмөрөн, М.Чаминцэцэг; Ред. Ц.Дэлгэрэхцэцэг.- УБ.: Соёмбо, 2017.- 304х.- (МУИС-ийн ШУС-ХУС).- ISBN 978-99973-79-98-6.



Энэхүү номд гадаад хэлний сургалтын өнөөгийн хөгжлийн чиг хандлага, баримталж буй стандарт, өргөн хэрэглэгддэг арга, технологийг тодорхойлж, хэлний түвшингүүдийн хэрэглээ, хэлэхүйн төрлүүдэд сургах онол, аргазүйн үндсэн ойлголтуудыг товч тайлбарласан ба гадаад хэл сургалтын гол гол аргуудыг ашиглахад суурилсан сурах бичгүүдээс үлгэр болгон зарим хичээлийг хавсаргасан байна.

81.2-9

Г-13

/НУН-унш-7, ГНОФ-10, ШУС-ХУС-10ш /

Т-18555-18557



Төмөртоого Д. ба бус. Хэл шинжлэлийн монгол-англи толь бичиг: 10000 орчим толгой үгтэй А-Я / Д.Энхбат, Ж.Бат-Ирээдүй; Эрхл. В.Дашдаваа.- Анхны хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 424х.- (Монгол хэл шинжлэлийн сан).- ISBN 978-99973-42-96-6.

Аливаа шинжлэх ухаанд хэвшсэн нэр томъёо хамгийн чухал ач холбогдолтой зүйл болохыг олон шинжлэх ухааны судлаачид онцлон тэмдэглэдэг. Энэхүү хэл шинжлэлийн толь бичиг нь их, дээд сургуулийн оюутан залуучууд, хэл шинжлэлийн чиглэлээр судалгаа хийж буй судлаачид болон сонирхогч хэн ч ашиглах боломжтой.

81.2-4

Т-58


/НУН-унш-3, ШУС-ХУС-8/

Б-24603-24604

АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

Аман зохиолын дээжис: Цуврал 8 боть / Ред. Э.Жаргалмаа; Бэлт. Т.Баясгалан.- УБ.: Соёмбо пресс, 2014.

Монгол ардын аман зохиол нь манай ард түмний үгийн урлаг, хэл соёлын шилдэг өв уламжлал билээ. Монголчуудын олон зууны турш ам дамжуулан хэлэлцэж ирсэн



үлгэр, домог, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, оньсого, таавар, тууль, ертөнцийн гурав, хууч яриа, хурим найрын болон хүүхдийн аман зохиол зэрэг бүхий л төрлөөс дээжлэн авч энэхүү 8 боть бүтээлийг толилуулж байна.

82.3(1)

/ НУН унш-4, ГНОФ-3ш /

М-69 Б. 1: Монгол ардын үлгэр.- 312х.- ISBN 978-99929-4-081-6.
Б-24635-24637

Б. 2: Монгол ардын домог.- 303х.- ISBN 978-99929-4-080-8. Б-24638-24640

Б. 3: Монгол ардын ерөөл магтаал.- 312х.- ISBN 978-99929-4-079-4.

Б-24641-24643

Б. 4: Монгол ардын зүйр цэцэн үг.- 303х.- ISBN 978-99929-4-077-8.

Б-24644-24646

Б. 5: Монгол ардын дуу.- 306х.- ISBN 978-99962-2-824-7.

Б-24647-24649

Б. 6: Монгол ардын тууль.- 297х.- ISBN 978-99929-4-070-6.

Б-24650-24652

Б. 7: Монгол хууч яриа.- 302х.- ISBN 978-99962-2-823-0.

Б-24653-24655

Б. 8: Зан үйлийн аман зохиол.- 228х.- ISBN 978-99962-2-822-3. Б-24656-24658

Эрийн сайн хан харангуй / Хэвлэлд бэлт. Т.Баясгалан; Ред. Ц.Жаргалсайхан.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 333х.- ISBN 978-99962-68-84-7.

“Ханхарангуй” хэмээх энэ гайхамшигт сайхан туулийг анх тэмдэглэж авсан хүн нь Финляндын нэрт монголч эрдэмтэн Г.Рамсдетт (1873-1950) ажээ. Тэрбээр Монголд хэдэн удаа ирж нутгийн аялгуу, аман зохиолын баялаг хэрэглэгдэхүүн цуглуулсан ба ингэж явахдаа Ханхарангуй туулийн нэгэн мөчлөг гэж үзэж болох Улаадаймэргэний үйл явдлыг харуулсан бүлэг хувилбарыг 1909 оны 10-р сарын 24-нд Өргөө хотод Алтангэрэл гэдэг хүнээс тэмдэглэж авсан байна. Монгол туулийн гурван оргилийн нэг гэж зүй ёсоор үнэлэгдсэн “Ханхарангуй” тууль нь дүр дүрслэл, бүтэц зохиомж, агуулга хэлбэр, гарал үүсэл, хөгжил хувьслын явц зэргээрээ үнэхээр олон оныг дамжсан, ардын аман яруу найргийн содон сайхан бүтээл билээ. “Ханхарангуй” тууль нь халх, өөлд, дөрвөд, баяд, торгууд, захчин, урианхай ялгалгүй бүхий л монгол овогтны дунд дэлгэрчээ.



82.3(1)

Э-75

Б-24718-24719

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ



Баясгалан С. **Бүтээлийн түүвэр** / Эрхл. Р.Ринчинбазар; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 272х.- ISBN 978-99973-2-697-3. Энэхүү түүвэрт Соёд овогт профессор Содовын Баясгалангийн түүх, улс төр, ахуй амьдрал гээд төрөл бүрийн сэдвээр бичсэн нийтлэл, нэжгээд ярилцлага хийгээд түүний хөрөг багтсан болой. Уншигч та эндээс зохиогчийн үгээр урлах чадвар, өргөн далайцтай оюуны цар, гүн гүнзгий эрэгцүүлэл, унасан газар, угаасан ус, удам судар, өв соёлоо өмөөрөх сэтгэл, “даруулгагүй өвгөн”-ий далд ертөнцийг олж харах болно.

83+63.3(1)-8

Б-38

T-18525

Мижидгомбо М. **Бурханы оронд мөнхөрсөн монгол хүн** / Эрхл. Р.Ринчинбазар; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 245х.- ISBN 978-99962-3-837-6.

Халхын Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, эдүгээгийн Архангай аймгийн Цахир сумын уугуул түүхч, зохиолч Рааш овогт Магсарын Мижидгомбо



агсаны бичиж үлдээсэн бүтээл, туурвилаас түүвэрлэн энэхүү номыг уншигчиддаа толилуулж байна. Эхний бүлэгт судалгаа, шинжилгээний бүтээл, удаах бүлэгт дурсамж, тэмдэглэл, нийтлэл, гутгаар бүлэгт шүлэг, өгүүллэг багтсан болно.

83+63.3(1)-8

М-52

Т-18526


МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ

Дүгэржав Ж. **Түүвэр зохиол** / Эрхл. Р.Ринчинбазар; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 306х.- ("Увдисын шүтээн" ХК).- ISBN 978-99973-3-751-1.

Монголын шинэ утга зохиолын түүхэнд нэр нь нэг их дурдагдаагүй, тийн атлаа ХХ зууны соёл урлагийн алтан үеийн их "галд" цучил нэмэрлэж явсан, уран зохиолын нэгэн "нэргүй баатар"-ын түүврийг уншигч олноо толилуулж байна. Энэхүү түүвэрт зохиолчийн урд нь хэвлэгдсэн номуудаас зарим зохиолыг сонгон оруулж, гар бичмэлээр хадгалагдан үлдсэн дөрвөн кино зохиолыг багтаасан болно.

84(1)

Д-74



Т-18524



Монгол уран зохиолын товчоон: Цуврал 1-9 / Ред. зөвлөх Х.Чилаажав, М.Эрдэнэбат, М.Саруулдалай ба бус.; Эх бэлт. Т.Дулмаа, Б.Үүрийнтуяа.- УБ.: Соёмбо пресс, 2007.- ISBN 978-999-29-4-157-Х.

Монголын уран зохиолын арвин их өв санг ийм цөөхөн ботид бүрэн төгс багтаах боломжгүй гэдэг нь тодорхой зүйл юм. Иймд уг ботид зохиолуудыг сонгохдоо МЗЭ-ээс эмхэтгэн гаргасан шилмэл бүтээлийн чуулган, эмхэтгэлүүд, цуврал ботиуд, "Утга зохиол-Урлаг" сонин, "Цог" сэтгүүлд нийтлэгдэж, үнэлэгдэж байсан байдлыг нь харгалзан үзсэн болно. Энэхүү бүтээлийг санаачлагчид цаашид уран зохиолын судлал шүүмжийн бүтээлүүд, орчуулга роман, туульсын томоохон бүтээлүүдийг цувралаар гаргах зорилготой.

84(1)


М-69

/НУН-унш-4, ГОФ-3, БС-1/

Цувр.1. -458х.	Б-24659-24661
Цувр.2. -432х.	Б-24662-24664
Цувр.3. -647х.	Б-24665-24667
Цувр.4. -548х.	Б-24668-24670
Цувр.5. -508х.	Б-24671-24673
Цувр.6. -550х.	Б-24674-24676
Цувр.7. -656х.	Б-24677-24679
Цувр.8. -606х.	Б-24680-24682
Цувр.9. -827х.	Б-24683-24685

Пүрэв Д. **Болор нүд:** Роман / Хян. П.Жаргалсүрэн, Ж.Бүжин, Э.Жаргалмаа.- 3 дахь хэвл.- УБ.: Соёмбо пресс, 2013.- 392х.- ISBN 978-99962-2-462-1.

Хүн болоод хүний оюун ухаанаар бүтээгдсэн шинжлэх ухааны аливаа бүтээлүүд ёс суртахуунтай байж ардаа хар мөр дагуулахгүйг сануулдаг билээ. ...Мэнгэт хэмээх залуугийн зүрхийг хэсэг хүмүүс хулгайлж нэгэн баян найздаа шилжүүлэн түүнийг



амьдруулна. Залуугийн бие нь шороонд булагдаж, зүрх нь баяны цээжинд цохилж харин сүнс нь тэнэнэ. Бурхан түүнд болор нүд өгснөөр хүний амьдралын сайн муу, ил далд бүхнийг мэдэж байгаа тухай сонирхолтойгоор энэ номонд өгүүлнэ.

84(1)-44

П-91

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24632-24634

Пүрэв Д. **Могой цэцэг**: Роман: Тэргүүн дэвтэр / Хян. П.Жаргалсүрэн, Ж.Бүжин, Э.Жаргалмаа.- 3 дахь хэвл.- УБ.: Соёмбо пресс, 2013.- 424х.- ISBN 978-99962-2-463-8.



Эх орноо хайрлаж уул ус, газар нутгаа хүндэтгэн лус хэмээх далд хүчинтэй нөхөрлөж Могой цэцэгийн ид шид, эрдэм чадлыг ашиглаж буй Цэрэн-Өлзий маарамбын амьдралыг уран сайхнаар энэ номонд өгүүлжээ. Энэ роман нь “Могойн сүү” романаар үргэлжлэх ажээ.

84(1)-44

П-91

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24629-24631



Пүрэв Д. **Улаан сүүний урсгал**: Роман / Хян. Я.Отгон, Ж.Бүжин, Э.Жаргалмаа.- УБ.: Соёмбо пресс, 2013.- 504х.- ISBN 978-99962-2-465-2.

Багш шавийн барилдлага хийгээд эцэг эхийн сайн муу үйлийн үр хожмоо үр хүүхдэд нь тусдаг билээ. Зохиогч хүн зөв санаатай, зөв амьдрахын чухлыг сануулан, их маарамбын хойт дүр Найдан хүүгийн амьдралын ээдрээтэй адал явдал өрнөсөөр эцэстээ урд насны гавж Хайдаваар илэрч, хорвоогийн үнэнийг үзүүлж байгаа тухай энэ романд өгүүлнэ.

84(1)-44

П-91

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24626-24628

Пүрэв Д. **Үлэмжийн цагаан бороо**: Гурамсан роман / Хян. П.Жаргалсүрэн, Л.Ихзаяа, Э.Жаргалмаа.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо пресс, 2013.- 808х.- ISBN 978-99962-2-461-4.


МЗЭ-ийн шагналт зохиолч Д.Пүрэв Говь-Алтай аймгийн Бугат сумын уугуул. Шашин, зурхай судлаач тэрээр "Гэмгүй цагаан дусал", "Гулзгай", "Сүнс", "Тогоо", "Хойт мөр" зэрэг 30 гаруй өгүүллэг, "Шамбал", "Сүүдэрцэцэг" зэрэг тууж бичжээ. 2009 онд анхны роман "Гавж"-аа гаргаснаас хойш "Хувилгаан", "Бумба" нэртэй II, III ботийг хэвлүүлснээр "Үлэмжийн цагаан бороо" нэртэй энэхүү гурамсан роман бүтсэн түүхтэй ба Жамьян-Осор хүү гавж, хувилгаан, бумбын ид шидээр эдүгээ хүртэл амьдарсаар байгаа тухай энэ романд өгүүлжээ.

84(1)-44

П-91

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24617-24619



Пүрэв Д. **Үүл нөмөрсөн уул**: Роман / Хян. П.Жаргалсүрэн, Ж.Бүжин, Э.Жаргалмаа.- УБ.: Соёмбо пресс, 2013.- 464х.- ISBN 978-99962-2-464-5.

Алтай хэмээх хүү ертөнцийг танин мэдэж хамгийн бага хэмжээс доод тоог олж хий биеийг эзэмшиж, тэрээр хүний биеийг бүрэн задалж эс рүү нэвтэрч нил улаан туяагаар хорт хавдрыг анагаан мөнх тэнгэрийн хүчээр хүмүүнд эрүүл мэнд, амь насны дээд өглөг бэлэглэсний учир Нобелийн шагнал хүртэж буйг энэ романд урнаар өгүүлжээ.

84(1)-44


П-91

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24620-24622

Пүрэв Д. **Чүнчигноров**: Роман / Хян. Я.Отгон, Ж.Бүжин.- УБ.: Соёмбо пресс, 2014.- 618х.- ISBN 978-99962-2-730-1.

Энэхүү роман нь монгол ёс уламжлалыг багтаан бичсэнээрээ онцлогтой юм байна. Уг романд Авирмэд, Чоймжүүр, Хайдавжамц, Сагад нарын удам дамжсан дөрвөн хүний ахуй амьдралд дээдсээс нь өвлөсөн монгол ухаан ямар их хэрэг болж байгаа тухай, мөн нутагтаа “мэргэн” хэмээн алдаршсан эгэл жирийн малчин Сагад өвөг дээдсийнхээ хөх ухааныг өвлөж, тэнгэрийн бичээс мэдээллийг уншиж, газрын зурлагыг шинжлэн магадалж, билгийн нууцад нэвтэрдэг тухай өгүүлнэ.




84(1)-44

П-91

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24623-24625



Санжаахүү Ё. **Тойн эрдэнийн домгийн мөрөөр** / Эрхл. Р.Ринчинбазар; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 306х.- (“Увдисын шүтээн” ХК).- ISBN 978-99973-3-751-1.

Хариад овогт Ёндонгийн Санжаахүү агсан телевизийн сэтгүүлч, редакторын цаг наргүй нөр их ажлынхаа хажуугаар 40 гаруй жил уран бүтээл туурвижээ. Энэхүү түүвэрт түүний яруу найргийн болон үргэлжилсэн үгийн зохиолууд, дурсамж, нийтлэл, тэмдэглэлээс түүвэрлэн оруулжээ. Уншигч та эндээс зохиогчийн үгээр урлах чадвар, өргөн далайцтай оюуны цараа, гүн гүнзгий эрэгцүүлэл, унасан газар, угаасан ус, удам судар, өв соёл, түүх уламжлалаа өмөөрөх сэтгэлийг олж харах болно.

84(1)-4

С-31

T-18527

ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ



Верн Ж. **Усан доогуур 20000 бээр аялсан нь** / Орч. Ц.Батцэнгэл; Ред. Д.Болдхуяг, Э.Түвшинбаяр.- УБ.: Монсудар, 2009.- 432х.- ISBN 978-99973-1-040-8.

Францын сод билэгт зохиолч Жюль Верн (1828-1905) бол энэрэнгүй үзэлтэн байсан төдийгүй, шинжлэх ухааны зөгнөлт зохиолыг үндэслэгч юм. Тэрээр тойрон аялах дуртай нэгэн байсан бөгөөд өөрийн “Сен-Мишель” хөлөг онгоцоороо Газрын дундад тэнгисийг хоёр удаа тойрч Итали, Англи, Шотланд, Ирланд, Дани, Голланд, Скандинавын орнуудад очиж байжээ. Түүний бичсэн олон сайхан зөгнөлт зохиолыг нь хүн төрөлхтөн зуун зууныг дамжин шимтэн уншсаар байна.

84(4Фр)-44


В-35

/ШУС-ХУС-1, ГНОФ-7ш/

Б-24698-24700

Клэр К. **Үхлийн зэвсэг**: 1-р дэвтэр: Ясан хот / Орч. Ж.Заяажаргал.- УБ.: Монсудар, 2015.-464х.- ISBN 978-99973-1-207-5.

Нью-Йорк хотод ээжтэйгээ амьдардаг жирийн нэгэн охин Клари нэгэн үдэш найз Саймонтой хамт Пандемониум клубт бүжиглэж байгаад эртний гэмээр шивээстэй өсвөр насны хүүхдүүд нэгэн хүүг мөрдөж буйг




ажиглаж, дагсанаар аллагын гэрч болно. Тэднийг Кларигаас өөр хэн ч харж чадахгүй бөгөөд жирийн хүнд харагдаж буйгаа мэдсэн алуурчид өөрсдийгөө дэлхийг чөтгөрөөс ангижруулах зорилготой Сүүдрийн ангуучид хэмээн тайлбарлана. Кларигийн ээж яагаад алга болов? Клари хэрхэн гэнэт ер бусын хараатай болсон?... үйл явдал цааш хэрхэн өрнөх талаар уншигч та энэхүү уран зөгнөлт номноос уншаарай.

84(7АНУ)-44

К-51

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24591-24593



Кобо А. **Элсний хүүхэн**: Роман / Орч. Ц.Цэнгэл.- УБ.: Соёмбо пресс, 2015.- 212х.- ISBN 978-99973-74-29-5.

Кобо бол 20-р зууны Японы нэрт зохиолч бөгөөд “Элсний хүүхэн” зохиол нь ихэд алдартай, Японы заавал унших ёстой 5 зохиолын нэг юм. Энэ номонд шавьж цуглуулах сонирхолдоо хөтлөгдсөн дунд сургуулийн багш Ники Зюмпэй, элсний шавьж хайхаар гараад буцаж ирээгүй тухай буюу элсний шавьж хайхаар гарсан хотын залуу өөрөө “элсний залуу” болсон тухай өгүүлнэ. Хүний амьдрахуйн зорилго, эрх чөлөөт байдал, хэн хүнийг эрх чөлөөгүй байдалд оруулдаг вэ? амьдралаа өөрчлөх боломж байдаг уу? байдаг бол ашиглаж чаддаг уу? гэх мэтийн асуултанд зохиолч, Ники Зюмпэй хэмээх гол дүрээрээ төлөөлүүлэн хариулахыг зорьжээ.

84(5Яп)-44

К-55

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24608-24610

Ларсон С. **Галаар наадсан охин**: Цуврал II боть / Орч. О.Гомбожав; Ред. Л.Мөнх.- УБ.: Монсудар, 2013.- 596х.- (Нью-Йорк таймс сонины бэстсэллэр зохиол).- ISBN 978-99962-0-546-0.

Компьютерын гарамгай мэргэжилтэн, няцашгүй Лизбет Саландер зорилгоо гүйцээх үүднээс бүх л зэвсгийг эзэмшиж сурна. Тэр ялзрал, завхрал, зүй бус үзэгдлийг ялангуяа эмэгтэйчүүд хүчирхийлүүлж, доромжлуулахыг огт тэвчихгүй, өршөөхгүй. Тэр хэзээ ч бууж өгдөггүй. Тэрээр хакерын гарамгай чадвараа ашиглан Millennium сэтгүүлийн сурвалжлагч Микаел Бломквистэд хүний наймаа, сексийн зах зээлийн нуугдмал хэргүүдийг илрүүлэхэд нь туслахаар шийддэг...

84(4Шв)-44

Л-24

/НУН унш-7ш/

Б-24701-24703



Ларсон С. **Зөгийн үүр бусниулсан охин**: Цуврал III боть / Орч. Ж.Тэгшзаяа; Ред. С.Мөнхбаяр, Э.Түвшинбаяр.- УБ.: Монсудар, 2014.- 652х.- (Нью-Йорк таймс сонины бэстсэллэр зохиол).- ISBN 978-99973-1-117-7.

Лизбет Саландер амь насыг нь хөнөөх гэсэн балмад эр болон амьдралыг нь нураан сүйдэлсэн төрийн институцээс өс хонзонгоо авна. Шударга бус тогтолцооноос болж айхтар хохирсон тэрээр хэнд ч итгэж болохгүйг яс махандаа шингэтэл ухаарсан боловч энэ удаад ганцаараа тэмцэж хүчрэхгүй байв. Мөр, толгойдоо буудуулж хүнд гэмтсэнээс болж эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлэх зуур түүний хамгийн заналт дайсан хажуу өрөөнд нь хэвтэнэ. Амьд гарах аваас хүн амины хэрэгт буруутгагдах аюул тосож байлаа. Цагдаагийн албан ёсны хамгаалалт дор Саландерыг зөвхөн эмч болон өмгөөлөгчтэйгөө харилцахыг зөвшөөрнө. Бломквист болон Millennium-ын сэтгүүлчдийн тусламжтайгаар Саландер өөрийн гэм буруугүйг нотлох хэрэгтэй болно...

84(4Шв)-44

Л-24

/НУН унш-7ш /

Б-24704-24706

Мартин Жорж Р.Р. **Гал мөсний дуун цуврал**: 1-р дэвтэр: Хаан ширээний тоглоом / Орч. Н.Энхнаран.- УБ.: Монсудар, 2014.- 576х.- ISBN 978-99973-1-090-3.



Орчин үеийн уран зохиолын салшгүй хэсэг болох уран зөгнөлт зохиолын хэлбэрээр бичигдсэн уг бүтээлд Винтерфеллийн Старкууд хэмээх нэгэн гэр бүл, лорд, эрхэмсэг хатагтай, хүлэг баатар, ид шидтэн, аврагч нар, зальхай этгээдүүдийг хамтад нь дүрсэлжээ. Старкууд нууц хуйвалдаан, хорт явуулга, уй гашуу, урван тэрслэл, ялалт, үхэл хагацал, гамшиг дунд өөрсдийн холбоотон болон дайснуудаа “Хаан ширээний тоглоом” хэмээх үхлийн тэмцэлд ялахын төлөө амь өрсөн тэмцэлдэх тухай өгүүлнэ.

84(7АНУ)-44

М-27

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18513-18515



Набоков В. **Лолита** / Орч. Д.Чойжил, Б.Бүдболд.- УБ.: Монсудар, 2008.- 430х.- ISBN 978-99962-0-788-4.

...Огт санаандгүй байтал тэнгисийн цэнхэр долгион зүрхэн тушаа минь хөвөлзүүлэн сэрүүн тавцангийн зэгсэн хивсэн дээрээс нарны гэрлийн дугуй цацрагууд дундаас нүцгэн шахуу миний Ривьерийн хонгор өвдөг дээрээ эргэлдэн хар шилнийхээ цаанаас намайг анхааралтай харж байлаа. Энэ бол тэр жаахан охин мөн байв... Хижээл насны нэгэн эр 12 настай бяцхан охинд дурласнаар өөрийгөө захирах жолоодлогогүй болж буйг харуулах энэ романыг сэтгэцийн эмгэгийн тухай роман гэж үзэх ч судлаачид байдаг. Юутай ч Лолитагаас өөр ямар ч хайр дурлалын зохиол жигшил зэвүүцэл төрүүлэхийн хэрээр шимтэн унших хүслийг ийм ихээр өдөөж байгаагүй билээ.

84(7АНУ)-44


Н-12

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24720-24722

Нобелийн шагналт өгүүллэг / Орч. Ц.Цэнгэл.- УБ.: Соёмбо пресс, 2015.- 412х.- ISBN 978-99973-74-31-8.

Нобелийн шагналт Уильям Батлер Ййтс, Жорж Бернард Шоу, Томас, 1930 оны Нобелийн шагналт Синклэр Льюис, Жон Голсуорси, Иван Алексеевич Бунин, Херман Хессе, Уильям Фолкнер, Пэр Лагерквист, Альбэр Камю, Иво Андрич, Жан- Поль Сартр, Михэль Анхель Астуриас, Ясүнари Кавабата, Сэмюэль Бэкхэт, Хэнрих Бёлль, Эуженио Монтале, Исаак Башевис-Зингэр, Габриэль Гарсиа Маркез, Нэдин Гордимэр зэрэг зохиолчдын 30 гаруй өгүүллэгийг мөн тэдний товч намтарыг энэ номонд оруулжээ.




84(0)

Н-65

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24614-24616



Рот В. **Босогч=Insurgent**: Роман / Орч. Н.Энхнаран; Ред. Б.Сувддулам.- УБ.: Монсудар, 2016.- 271х.- ISBN 978-99973-1-251-8.

Нью-Йорк Таймсын бестселлер номын зохиолч Вероника Ротын “Хосолмол” цувралын хамгийн их хүлээгдсэн ном болох хоёрдугаар ном “Босогч” ахин сэтгэл хөдлөм баярын түүх, хүнд шалгуур, зүрх зүсэм явдал, хайр дурлал, хүний мөн чанарын тухай ойлголтоор дүүрэн билээ. ...Трисийн төгсөх ёслолын өдөр түүний сонгосон бүлэгтээ байгуулсан ялалтын өдөр байсан ч өгүүлэхийн аргагүй аймшигаар дуусна... Үйл

явдал хэрхэн өрнөж, дуусахыг уншигч та “Хосолмол” цувралын энэ номноос үргэлжлүүлэн уншаарай.

84(7АНУ)-44

P-79

/НУН унш-4, ГНОФ-3ш/

T-18602-18604

Рот В. **Дагалдагч=Allegiant**: Роман / Орч. Н.Энхнаран; Ред. Т.Ариунсанаа.- УБ.: Монсудар, 2016.- 294х.- ISBN 978-99973-1-338-6.


Нью-Йорк Таймсын бестселлер номын зохиолч Вероника Ротын “Дагалдагч” номныхоо үйл явдлыг өөр өөрийн өнцгөөс өгүүлэх хоёр хүүрнэгчээр дамжуулж уншигчид хүргэж байна. Энэхүү боть “Хосолмол” цувралын өмнөх “Хосолмол”, “Босогч” ботиудыг уншсан сая сая уншигчийн сайн мэдэх сүйрлийн ертөнцийн нууцыг илчилж, цувралыг гайхалтай эрч хүч дүүрэн төгсгөх болно.

84(7АНУ)-44

P-79

/НУН унш-4, ГНОФ-3ш/

T-18599-18601



Рот В. **Хосолмол=Divergent**: Роман / Орч. Н.Энхнаран; Ред. Э.Түвшинбаяр.-УБ.: Монсудар, 2014.- 267х.- ISBN 978-99973-1-130-6.

Нью-Йорк Таймсын бестселлер номын зохиолч Вероника Рот сэтгэл хөдөлгөм шийдвэр, зүрх шимшрэм урвалт, гайхаж цочирдом үр дагавар, санаанд оромгүй хайр дурлалын түүхээр дүүрэн “Хосолмол” цувралын энэхүү тэргүүн ботиороо утга зохиолын ертөнцөд дуулиан тарьсан ажээ.

84(7АНУ)-44

P-79

/НУН унш-4, ГНОФ-3ш/

T-18605-18607

Толстой Л.Н **Анна Каренина** / Орч. Ш.Очирбат; Ред. Г.Хавчуур.- УБ.: Монсудар, 2009.- 816х.- ISBN 978-99973-1-037-8.

Зохиолчийн алдрыг дэлхийд өргөсөн "Дайн ба энх" романы дараа орох хоёр дахь энэ том бүтээлд мөнхийн сэдэв болох хайр сэтгэлийн тухай хөндөнө. Нөхөрт гарсан баян хатагтай Анна Каренинагийн жавхаалаг офицер Вронскийд өгсөн эмгэнэлт, нууц дурлалын түүхийг өөр нэгэн хос болох Константин Левин, Китти Щербацкая нарын аз жаргалтай, цэвэр ариун хайрын өнгөн дээр тод томруунаар ялган харуулна. Өнгөц харахад Аннагийн бүх зүйл бүтэмжтэй мэт, хэргэм язгуур өндөр эр нөхөр, хайрт хүү, эд хөрөнгө хийгээд ихэс дээдсийн хүрээлэлд өөрийн байр сууриа олсон гээд амьдралаас өөр юуг ч хүсэх вэ дээ гэмээр гял цал бууна. Гэвч сэтгэлийнх нь гүнд өчүүхэн гэмээр хоосон зай оршоор ирсэн нь хайр сэтгэлийн аз жаргалд тэмүүлэх оргилуун хүслэн байлаа...

84(2Орос)-44

T-47

/ШУС-ХУС-2, ГНОФ-7ш /

B-24695-24697



Харүки М. **1Q84**: 1-р дэвтэр: Роман / Япон хэлнээс орч. О.Жаргалсайхан; Ред. К.Шиничи.- УБ.: Монсудар, 2014.- 409х.- ISBN 978-99973-1-088-0.

Японы төдийгүй дэлхийн пост модерн уран зохиолын гол төлөөлөгч Мүраками Харүкигийн алдарт “1Q84” цуврал бүтээлийнхээ санааг 1995 онд Токио хотын метронд хорт хий тавьж олон хүний амь насыг сүйтгэсэн “Ум шинри кёо” шашны байгууллагын өдүүлсэн гэмт хэргийн бодит түүхээс авсан бөгөөд өөрт нь маш ихээр нөлөөлсөн кино, хөгжим, утга зохиолоос иш татаж, зохиолдоо шигтгэж өгснөөр уншихад энгийн

ойлгомжтой хэрнээ аялгуу хэмнэл сайтай, нарийн мэдрэмж, төсөөлөхүй дагуулсан онцлог бүтээл болж чаджээ.

84(5Яп)-44

Х-23 /НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/ Т-18608-18610

Харүки М. **1Q84**: 2-р дэвтэр: Роман / Япон хэлнээс орч. О.Жаргалсайхан; Ред. К.Шиничи.- УБ.: Монсудар, 2014.- 378х.- ISBN 978-99973-1-089-7.

Японы төдийгүй дэлхийн пост модерн уран зохиолын гол төлөөлөгч Мүраками Харүкигийн алдарт “1Q84” цуврал бүтээлийнхээ санааг 1995 онд Токио хотын метронд хорт хий тавьж олон хүний амь насыг сүйтгэсэн “Ум шинри кёо” шашны байгууллагын өдүүлсэн гэмт хэргийн бодит түүхээс авсан бөгөөд өөрт нь маш ихээр нөлөөлсөн кино, хөгжим, утга зохиолоос иш татаж, зохиолдоо шигтгэж өгснөөр уншихад энгийн ойлгомжтой хэрнээ аялгуу хэмнэл сайтай, нарийн мэдрэмж, төсөөлөхүй дагуулсан онцлог бүтээл болж чаджээ.

84(5Яп)-44

Х-23 /НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/ Т-18611-18613



Харүки М. **1Q84**: 3-р дэвтэр: Роман / Япон хэлнээс орч. О.Жаргалсайхан; Ред. К.Шиничи.- УБ.: Монсудар, 2015.- 457х.- ISBN 978-99973-1-188-7.

Японы төдийгүй дэлхийн пост модерн уран зохиолын гол төлөөлөгч Мүраками Харүкигийн алдарт “1Q84” цуврал бүтээлийнхээ санааг 1995 онд Токио хотын метронд хорт хий тавьж олон хүний амь насыг сүйтгэсэн “Ум шинри кёо” шашны байгууллагын өдүүлсэн гэмт хэргийн бодит түүхээс авсан бөгөөд өөрт нь маш ихээр нөлөөлсөн кино, хөгжим, утга зохиолоос иш татаж, зохиолдоо шигтгэж өгснөөр уншихад энгийн ойлгомжтой хэрнээ аялгуу хэмнэл сайтай, нарийн мэдрэмж, төсөөлөхүй дагуулсан онцлог бүтээл болж чаджээ.

84(5Яп)-44

Х-23 /НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/ Т-18614-18616

Харүки М. **Өнгөгүй Тазаки Цүкүрү ба түүний эргэлийн он жилүүд**: Роман / Япон хэлнээс орч. О.Жаргалсайхан; Ред. К.Шиничи.- УБ.: Монсудар, 2016.- 288х.- ISBN 978-99973-1-323-2.


Тазаки Цүкүрү ахлах сургуульдаа дөрвөн сайн найзтай байв. Тохиолдлоор ч тэрүү найзууд нь цөм өнгө орсон нэртэй байжээ. Нэг өдөр найзууд нь Тазаки Цүкүрүд цаашид найзалж, нийлэхээ больё, дахиж чамтай уулзах ч үгүй хэмээн мэдэгдэнэ. Тэр өдрөөс хойш Цүкүрү хэнтэй ч дотно холбоо үүсгэж нөхөрлөж, үерхэж чадалгүй салхинд хийссэн бөмбөлөг мэт амьдрах болжээ...Уншигч та үргэлжлэлийг энэ номноос уншина уу.

84(5Яп)-44

Х-23 /НУН унш-4, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/ Т-18617-18619



Юкио М. **Алтан сүм**: Роман / Орч. Ц.Цэнгэл.- УБ.: Соёмбо пресс, 2015.- 310х.- ISBN 978-99973-74-30-1.



Юкио Мишима (1925-1970) дэлхийн II дайны дараах үеийн Японы сод зохиолчдын нэг бөгөөд Нобелийн шагналд хэдэнтээ нэр дэвшиж байсан “Алтан сүм” роман нь дэлхий нийтийн хамгийн их уншдаг япон зохиолуудын эхэнд бичигддэг ажээ. Зохиолын гол дүр нь Мизогути нь хөдөөгий ядуу ламын хүү бөгөөд бие султай, ээрүү учраас зориггүй, сул дорой, аймхай, зожиг ганцаардмал нэгэн. Мизогутигийн аав нь үргэлж Алтан сүмийн гоо үзэсгэлэнг бишрэн бахаддаг байсан агаад аавыгаа нас барсны дараа тэрээр Алтан сүмд амьдарч эхэлдэг. ...Алтан сүм түүний хувьд төгс хийгээд мөнхийн гоо үзэсгэлэнгийн илэрхийлэл бөгөөд амьдралдаа ямар нэг алхам хийх бүрт түүний дотор Алтан сүмийн үзэсгэлэнт төрх сүүмэлзэн гарч ирэх бөгөөд ингэх бүрийд тэр юу ч хийж чадахаа больдог тухай, мөн үйл явдал цаашид хэрхэн өрнөхийг уншигч та энэ номноос уншаарай.

84(5Яп)-44

Ю-24

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24611-24613

УРАН БАРИЛГА



Вилкинсон Ф. **Аугаа барилгууд**: Дэлхийн уран барилгын сор бүтээлүүдийг шинжлэн тайлбарлав / Орч. Т.Ариунсанаа; Ред. Д.Хүрэлхүү.- Сингапур., 2012.- 256х.- ISBN 978-99973-66-52-8.

Манай гариг дэлхий дэх хүний гараар бүтээгдсэн гайхамшигт бүтээлийг уран барилга хэмээн ойлгож болно. Аугаа барилгуудын өөр өөр уламжлал, ондоо ондоо соёлын нөлөөн дор бүтээгдсэн тухай мөн хамгийн онцгой содон барилгуудыг энэ номонд нарийвчлан шинжиж харуулах болно. Байгаль орчинд ойр дөт шийдэлтэй орон сууцнаас эхлээд итгэл бишрэл төрүүлсэн сүм мөргөлийн орон, албан газрын зай, эзлэхүүнийг хэрхэн төлөвлөдгийг ч мэдэж авна. Энэ мэдлэг нь уран барилга, барилга байгууламжийг бодитой мэдрэн үнэлэх, бахдах чадварыг төрүүлж, тэдгээрийг бүтээсэн уран бүтээлчдийн авьяасыг үнэлэн бахдах, таашаах боломж олгоно.

85.11+38я2

В-44

/НУН унш-3ш/

Т-18560-18561


ШАШИН СУДЛАЛ

Буддын мэдлэг ухааны хөгжилд монгол мэргэдийн оруулсан хувь нэмэр: Олон улсын эрдэм шинжилгээний хурал / Эрхл. Р.Ринчинбазар, Г.Чулуунбаатар, Д.Чулуунжав; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 177х.- ISBN 978-99973-3-750-4.

Улаанбаатар хотноо 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр “Ханбүргэдэй” ХХК-ийн хурлын танхимд ШУА-ийн Философийн хүрээлэн, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим, Азийн буддистуудын энх тайвны бага хурал хамтран халхын их эрдэмт лам гэвш Сэнгээ ринбүчийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан билээ. “Сэнгээ гэвш” номонд хурлын нэгжээд илтгэл хэвлэгдсэн бөгөөд тэнд ороогүй материалуудыг эмхэтгэн энэ товхимолыг бэлтгэн гаргажээ.

86.35

Б-69



Т-18522



Мөнхрөхүйн увдис / Эрхл. Р.Ринчинбазар; Хян. С.Отгонцэцэг; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 312х.- ISBN 978-9997-3-752-8. Энэхүү номонд хүн төрөлхтөний өмнө гайхамшгийг үзүүлж, анх оршоосон лагшин төлөвөө цаашид төнх байх мэт эдүгээг хүртэл хадгалсаар буй тойн эрдэнэ Ц.Чүлтэмжамц, аграмба Р.Санжаажав, хамба лам Д.Итгэл нарын тухай өгүүлэх болно. Тэдний лагшин төлөвт шилжсэн төстэй байдал, хүмүүсийн оюун санаанд нөлөөлж буй эрдэм чадлын адил увдис, зэрэг зиндаа, монгол генийн нэг иш үндэс нь чинад оршихуйн учир шалтгаан байж болох юм. Онцгой содон үзэгдэл юмс, тайлагдаагүй нууцыг сонирхон судлаачид хийгээд өргөн олон уншигчдад зориулав.

86.4
М-81

T-18523


Ринбучи **Таны алган дахь дарь эх**: Махасидда сурья гупта уламжлалаар хорин нэгэн дарь эхийг тахиx ёсон / Орч. Д.Халиун; Эрхл. Р.Ринчинбазар; Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 168х.- ISBN 9789996238253.



Энэхүү номыг эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд ариун сургааль хийгээд өлзий хутагт Дарь Эхэд сүсэглэхийн тухайд бүтээсэн болой. Өдөр тутам хорин нэгэн Дарь Эхийн магтаалыг уншин, Дарь Эхийг тахиx ёсыг баримтлах аваас Дарь Эхийн өлзий хутгийг олж өөрсдөө Дарь Эхэд хувирах нигууртай бөлгөө. Уламжлалт ном сургааль дээр үндэслэсэн энэхүү гарын авлага нь хүн бүрт Дарь эхийг өөртөө одуулахад зориулагдсан болно.

86.35
P-51

B-24582



Сэнгээ гэвш: Түүх, сурвалжийн товчоон / Санаачилсан М.Мижидгомбо; Эрхл. Р.Ринчинбазар.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 364х.- ISBN 978-99973-3-748-1.

Энэхүү номонд Дарамбазарын Сэнгээ нь (1905-1993) багадаа тойн хувраг болж, номын мөр хөөн Халх нутгаас гарч замын саад бэрхшээлээс үл шантран Цаст Түвдэд очиж 65 жил суухдаа эрдмийн мэргэдтэй нь номын ураг барилдаж буяны садан гэвш болоод улмаар шашны онол, гүн ухааны ба судар тарнийн номонд мэргэшин гэвш, лхарамба, аграмбын дамжаа барьж, хожим нь Түвдийн тэргүүлэх хийдүүдийн нэг Сэра хийдийн тэргүүн хамба болсон намтар, түүхийг нь өгүүлэх ажээ.

86.35
C-94

T-18521

ГҮН УХААН, ЁС СУРТАХУУН

Дарьхүү Р., Эрдэнэбаяр Г. **Философийн түүх** / Хян. Г.Лодой, Д.Оюунгэрэл.- 4 дэх хэвл.- УБ.: Тотопресс, 2016.- 389х.- (МУИС-ийн ШУС-ХУС).- ISBN 978-99978-4-226-3.

Философийн түүхийг судалснаар хүмүүн өөртөө тулгарад байгаа асуудлыг сайтар нягталж, олон хувилбараар сэтгэж, ухаалаг шийдвэр гаргах чадвартай болдог. Философийн түүхээс суралцах нь ухаалаг үндэслэлийг гаргах, үзэгдэл, үйл явцын ялгаа ба хамаарлыг олж тогтоох, өөрийн гэсэн бие даасан үзэл бодол, байр суурьтай болох,



ерөнхийлөн дүгнэх, нөхцөлийг тайлбарлах, нухацтай сайн асуулт тавих чадвар, учрыг олоход уриалах, ойлголтыг тодорхойлох зэрэг сэтгэлгээний олон чухал чадварыг бидэнд төлөвшүүлдэг.

87.3

Д-38

/ НУН унш-7, ШУС-ХУС-8ш /

Т-18571-18573



Кондо М. Амьдралыг өөрчлөх эмх цэгц ба түүний гайхамшигт ид шид: Салан задгай байхаа больж, эмх цэгцтэй амьдрах япон ухаан / Орч. Л.Саруултөгс.- УБ.: Монсудар, 2016.- 238х.- ISBN 978-99973-1-341-6.

Кондо Мари энэ номондоо “гэр болон албан тасалгаагаа дахин хэзээ ч хөглөрөхгүй байхаар нэг л удаа цэгцлэх арга”-ыг танилцуулсан ба “Юун түрүүнд хэрэгцээгүй зүйлсээ хаях хэрэгтэй. Түүний дараа нэг дор, богино хугацаанд, бүрэн гүйцэд эмхлэн цэгцлээрэй. Энэ бүгдийг зөв арга барил, зөв дэс дарааллаар хийж гүйцэтгэвэл таны гэр орон дахин хэзээ ч хөглөрөхгүй” гэсэн байна. Таван настайгаасаа эхлэн эмхэлж цэгцлэх ажилд шимтэн дурлаж, энэ талаар уншиж судлан, төрөл бүрийн арга барил туршиж үзсэний үндсэн дээр боловсруулсан түүний энэ арга барилыг хэрэгжүүлээд эмх цэгцтэй болж, гайхамшигтай гэмээр ид шидийг амьдралдаа бий болгосон хүмүүс Японд төдийгүй дэлхий даяар олон болжээ.

87.815

К-64

/НУН унш-7, ШУС-НУС-1ш/

Б-24723-24725

Ёс суртахууны удирдамж: Насан туршийн боловсролын сурах бичиг / Орч. ред. Б.Оюунцэцэг.- Токио: Изава хэвлэлийн компани, 2016.- 81х.

Япон дахь “Ёс суртахууны шинжлэх ухааны судалгааны хүрээлэн”-гээс насан туршийн боловсролд зориулан энэхүү цуврал номыг хэвлүүлжээ. Ёс суртахууны шинжлэх ухааны үндсэн тулгуур ойлголтууд, орчин үеийн нийгмийн асуудлыг эргэцүүлэн бодох, шийдвэрлэхэд дэм болох ёс суртахууны аргачлалын талаар энгийн үг хэллэгээр өгүүлэх энэхүү сурах бичгийг уншигч та уншсанаар хүн төрлөхтөний аз жаргал, амьдралын утга учрын талаар тунгаан бясалгаж, өндөр ёс суртахууны зан төлөв, сэтгэлийн зөв чиг хандлагатай болох арга ухаанд суралцах ажээ.

87.7

Ё-99

/НУН унш-5, ГНОФ-3ш/

Т-18630-18631



Ёс суртахууны шинжлэх ухааны ерөнхий онол: Насан туршийн боловсролын сурах бичиг / Орч. ред. Б.Оюунцэцэг.- Токио: Изава хэвлэлийн компани, 2016.- 104х.

Ёс суртахууны шинжлэх ухааныг системтэйгээр сурах хүмүүст зориулагдсан энэ сурах бичигт ёс зүй, ёс суртахууны зорилго, аз жаргалыг бүтээх, хамтын нөхөрлөл, энгийнээс дээд ёс суртахуунд хүрэх, “би” төвт үзэл, шударга ёс, үүргээ биелүүлэх, дотоод итгэл үнэмшил, гэр бүл, улс нийгмийн амьдрал, өөрийн болон бусдын сэтгэлийг хөгжүүлэх, үр дагаварын ёс зүйн талаар энгийн үг хэллэгээр өгүүлжээ.



87.7

Ё-99

/НУН унш-5, ГНОФ-3ш/

Т-18628-18629

НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ, НЭВТЭРХИЙ ТОЛЬ БИЧИГ

МУИС-ийн номын сангийн ном зүйн бүртгэл-I: Ном 2011-2015 он:

Бүртгэн мэдээлэх, санамж өгөх ном зүй / Эмхт. М.Кунай; Ерөн. ред. О.Нарантуяа; Ред. М.Намжилмаа, Ц.Туяа, Г.Цэнд-Аюуш.- УБ.: Бемби сан, 2017.- 724х.- (МУИС-ийн Номын сан).- ISBN 978-99978-0-305-4.



Энэхүү ном зүйн бүртгэлд МУИС-ийн номын санд 2011-2015 онд шинээр нэмэгдсэн монгол, орос, англи, герман хэл дээрх, мөн уйгаржин бичгээр хэвлэгдсэн 2316 нэр төрлийн номыг өнгөт зураг, товч агуулгатай нь оруулжээ. Номын бүтцийг зохион байгуулахдаа шинжлэх ухааны ангиар, анги дотроо зохиогчийн үсгийн дарааллаар байрлуулж, мөн хүний нэрийн хэлхээс, газар зүйн нэрийн хэлхээс, товчилсон үгийн тайлбар зэргийг оруулж өгснөөрөө онцлог болсон.

91

М-69

/НУН-унш-3, БУН-унш-3, Лав-1ш/

Т-18510-18512



МУИС-ийн Завхан сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн ном зүй: Сургуулийн 40 жилийн ойд зориулав / Эмхт. Б.Дэмид.- УБ.: Удам соёл, 2014.- 83х.- ISBN 978-99973-64-87-6.

Энэхүү эрдэм шинжилгээний бүтээлийн ном зүйд МУИС-ийн Завхан салбар сургуулийн 20 гаруй багш нарын эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, судлагааны ажил, гаргасан ном сурах бичгийн жагсаалтыг нэг бүрчлэн танилцуулжээ.

91.9:74

М-69

Т-18620

Монгол судлалын нэвтэрхий толь: 8 боть: Уйгаржин монгол бичгээр.- ӨМӨЗО.: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Энэхүү Монгол судлалын нэвтэрхий толийг уйгаржин монгол бичгээр гаргасан ба боть бүрт өргөн олон агуулгыг хамруулсан нь тодорхой. Тухайлбал зан үйл, аж ахуй, шашин суртахуун, гүн ухаан нийгмийн үзэл санаа, сонин мэдээ хэвлэл, цэргийн явдал, анагаах ухаан, биеийн тамир гэх мэтчилэн агуулгыг хамруулан уншигчдаа хүргэж байна. Мэдээж энэхүү нэвтэрхий толийг бүтээхэд асар их цаг хугацааг ашиглан бүтээсэн үнэ цэнэтэй бүтээл юм.

92

М-69

Т-18588-18595

- Б.1. Гүн ухааны нийгмийн үзэл санааны түүх.- 2010.- 843х.- ISBN 978-720410733-9.
- Б.2. Шашны суртахуун.- 2007.- 834х.- ISBN 978-720409165-2.
- Б.3. Зан үйл.- 2010.- 781х.- ISBN 978-720409908-5.
- Б.4. Сонин мэдээ хэвлэл.- 2003.- 702х.- ISBN 978-720407021-6.
- Б.5. Цэргийн явдал.- 2012.- 1139х.- ISBN 978-720410756-8.
- Б.6. Аж ахуй.- 2009.- 1197х.- ISBN 978-720409872-9.
- Б.7. Анагаах ухаан.- 2002.- 1164х.- ISBN 978-720406201-9.
- Б.8. Биеийн тамир.- 2011.- 636х.- ISBN 978-720411100-8.



ОРОС ХЭЛ ДЭЭРХ НОМУУД



Баяртсайхан Н. **К некоторым проблемам государственного регулирования экономики**: На примере Монголии.- Иркутск: Изд-во Байкальского госуниверситета, 2017.- 160с.- ISBN 978-5-7253-2939-1.

В настоящей монографии на примере Монголии отражены проблемы формирования системы государственного регулирования экономики в условиях социально-экономической трансформации, рассмотрены теоретические основы и функции такого регулирования, показано развитие рыночных отношений в условиях преобразования собственности, отмечена необходимость усиления регулирующего воздействия государства, изучены возможности расширения форм и методов государственного регулирования экономики и активизации функций бюджетно-налоговой системы в Монголии, сделаны конкретные выводы, на основе которых высказаны предложения по совершенствованию методов денежно-кредитного регулирования социально-экономических процессов.

65.050/1/


Б-34

С-84781-84783

АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ НОМУУД

Mongolian journal of physics: Issue 2: Special issue for the Proceedings of the 6th International conference on contemporary physics / Ed.by S.Davaa; Comp.by S.Odmaa.- UB.: Munkhiin useg, 2016.- 562p.

The 6th International conference on contemporary physics (ICCP-VI) took place in Ulaanbaatar, Mongolia, 7-10 June 2016. The ICCP-VI aims to provide a good opportunity for expert working in various topics of Contemporary Physics to discuss the latest research activities, to consider the prospects of applications and to stimulate interdisciplinary exchanges. This conference also provides the opportunity for round table discussions on special cross-disciplinary issues.




22.3

М-81

/ШУС-БУС-2III/

15168-15170



Roinson W. and oth. **Undergraduate instrumental analysis** / M.Skelly, M.Frame.- 7th ed.- USA.: Taylor and Francis Group, 2014.- 1231p.- ISBN 978-1-42006135-2.

Crucial to research in molecular biology, medicine, geology, food science, materials science, and many other fields, analytical instrumentation is used by many scientists and engineers who are not chemists. **Undergraduate Instrumental Analysis**, Seventh Edition provides users of analytical instrumentation with an understanding of these instruments, covering all major fields of modern instrumentation. Following the tradition of earlier editions, this text is designed for teaching undergraduates and those with no analytical chemistry background how contemporary analytical instrumentation works, as well as its uses and limitations.


24.4

Р-67

/ШУС-БУС-1III/


Simek J. W. **Organic chemistry**.- 8th ed.- USA.: Pearson, 2013.- 701p.

Acclaimed for its clarity and precision, Wade's **Organic Chemistry** maintains scientific rigor while engaging students at all levels. Wade presents a logical, systematic approach to understanding the principles of organic reactivity and the mechanisms of organic reactions.



S-61

/ШУС-БУС-1III/



Tungalag R. **The Flowers of the Mongolian Gobi Desert** / Edit. B.Boldgiv.-
UB.: Admon, 2016.- 333p.- ISBN 978-99973-51-28-9.


When A Field Guide to the Trees and Shrubs of Mongolia was published four years ago, some of my friends and colleagues advised me to continue and compile a guide on plants of the Gobi Desert. Domestic tourism sector has been expanding in recent years ...

T-93

/ШУС-БУС-5, ГФ-1ш/

Wade L.G. **Organic chemistry**.- 8th ed.- USA.: Pearson., 2013.- 1258p.

Acclaimed for its clarity and precision, Wade's ***Organic Chemistry*** maintains scientific rigor while engaging students at all levels. Wade presents a logical, systematic approach to understanding the principles of organic reactivity and the mechanisms of organic reactions. This approach helps students develop the problem-solving strategies and the scientific intuition they will apply throughout the course and in their future scientific work. The **Eighth Edition** provides enhanced and proven features in every chapter, including new Chapter Goals, Essential Problem-Solving Skills and Hints that encourage both majors and non-majors to think critically and avoid taking "short cuts" to solve problems. Mechanism Boxes and Key Mechanism Boxes strengthen student understanding of Organic Chemistry as a whole while contemporary applications reinforce the relevance of this science to the real world.



W-11

/ШУС-БУС-1ш/

[illegible]